МАНАЙ СОНИНЫ I УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,119.884... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.12.08. Пүрэв. №224, 225 (4594, 4595) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




ЦАГ ҮЕ

“БИЧИЛ УУРХАЙГ АЛБАЖУУЛАХАД ТАЛУУДЫН ОРОЛЦОО” ЧУУЛГАН БОЛОВ

V нүүрт

чухал ХҮН

Г.САМПИЛ: НҮҮДЛИЙН МАЛ АЖ АХУЙГАА УСТГАВАЛ МОНГОЛЧУУД СҮЙРНЭ

VI-VII нүүрт

Дугаарын 60 мөр

## Хувь хүний малыг тоолж, мөнгө үрэх хэрэг байна уу

Н.БАТЗАЯА

Манай улсад ноёрхож байсан социализмын үе аль хэдийнэ ард хоцорч, 30 гаруй жил болсон ч өнгөрсөн нийгмийн зарим буглаа эдүгээг хүртэл төр засгийн бодлогод ч шигдсэн хэвээр буй. Түүний нэгээхэн жишээ гэвэл мал тооллогын ажил. Аль нэгдлийн үед л явуулдаг байсан мал тооллого одоо болтол явагдаж, жил бүр төсвөөс мөнгө зарцуулдаг. Нэгэнт ардчилсан хувьсгал гарч эд хөрөнгө хувьд шилжсэнээс хойш тэр хувь малчны хөрөнгийг төсвөөс мөнгө гарган барин тоолох шаардлага байна уу. Яах вэ, малын хөлийн татвар авдаг бол ч тооллого явуулъя гэхсэн. Гэтэл ямар нэгэн татвар ч авсан юмгүй байж ёстой л өрөөлд ч хэрэггүй, өөрт ч ашиггүй ажлыг л ард түмний татварын мөнгөөр явуулж байх юм.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# АН-ЫГ “ХОВ, ХОР, ХОГ” ГУРВААСАА САЛСАН ЭСЭХИЙГ ЦАГ ХУГАЦАА Л ХАРУУЛНА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ж.ОТГОН

Ардчилсан намын VI их хурал бараг арван жил завсарласны дараа өнгөрсөн мягмар гарагийн морин цагт эхэлсэн. Их хурлын нээлт ялагдлын шалтгаанаа ярих, дүгнэх хариуцлагатай түүхэн үйл явдал гэхээсээ илүү ялсан намын баярын хурал шиг л эхэлсэн. Сонгуульд ялалт байгуулсан аймаг, сум дүүргүүдийн төлөөлөгчдөд намын дарга З.Энхболд, Л.Эрхэмбаяр, Н.Алтанхуяг, Ч.Сайханбилэг нар баяр хүргэж, намын туг гардуулах ёслол болсон. Алга ташилт инээд хөөрөөр эхэлсэн хурал үүний дараа намын дарга З.Энхболдын улс төрийн илтгэлээр үргэлжилсэн юм.

Үргэлжлэл нь III нүүрт




УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

# Д.ЭРДЭНЭБАТ: НАМЫН ДАРГАА НИЙТ ГИШҮҮДЭЭРЭЭ СОНГОНО ГЭДЭГ ФРАКЦГҮЙ БОЛЖ БУЙН ТОД ЖИШЭЭ

Ж.ОТГОН

*АН-ын VI Их хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар Их хурлыг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбаттай цөөн хором ярилцлаа.*

**-Их хурлаас нэлээд их хүлээлт байсан. Гэтэл дүрэмд л нэмэлт, өөрчлөлт оруулах юм байна. Энэ тохиолдолд Их хурал зарлан хуралдуулсны хэрэг гарч байгаа юм уу?**

-Их хурлаар өчигдөр /өнгөрсөн мягмар гарагт/ намын даргын илтгэл, Шинэтгэлийн хөтөлбөрийг хэлэлцсэн. Өнөөдөр /өчигдөр/ АН-ын үндсэн дүрмийн өөрчлөлт хэлэлцэж байна. Үе шаттай ажиллана. Асуудлыг сэтгэлийн хөөрлөөр 1100 хүний хүрээнд алх цохиод шийдчих шиг амархан юм байхгүй. АН энэ Их хурлаар юуг их онцолж харж байна вэ гэвэл ирээдүйнхээ чиг хандлага, үзэл баримтлал, зохион байгуулалтыг яаж авч явах юм гэдэг нь туйлын тулгамдсан асуудал учраас намын дотоод үзэл баримтлалын зохион байгуулалтын шинэчлэл бол үйл явц юм гэж харж байгаа.

Үргэлжлэл нь II нүүрт




| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах | Худалдаа хөгжлийн банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2469.00 | 2478.00 | ФУНТ | 3072.00 | 3175.00 | АМ.ДОЛЛАР 2466.00 | 2480.00 | ФУНТ | 3091.00 | 3192.00 |
| ЕВРО | 2611.00 | 2680.00 | РУБЛЬ | 37.10 | 40.30 | ЕВРО 2615.00 | 2702.00 | РУБЛЬ | 37.76 | 41.00 |
| ИЕН | 21.38 | 21.80 | ЮАНЬ | 357.70 | 360.40 | ИЕН 21.37 | 22.11 | ЮАНЬ | 357.00 | 362.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Шилдэг залуу багшийг шалгаруулна

УИХ-ын гишүүн доктор Ph.D Н.Учрал “Yes! Mongolia” Монголын залуу багш нарын холбоог 2015 оноос удирдаж ирсэн байна. Тэрбээр уг холбоог удирдаж ирсэн цагаасаа үйл ажиллагаанд нь тодотгол хийж, олон улсын багш нарын холбоо, Юнескод зөвлөх эрхтэй байгууллага болгон өргөжүүлж ажилласан аж. Үүнээс гадна “Сургалтын боловсролын дэлхийн зөвлөл”-ийн албан ёсны гишүүний үүргийг биелүүлж олон улсын сүлжээнд нэгтгэх, гадаад дотоодын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах гэх мэт чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа гэнэ. Тус холбоо нь 21 аймаг, есөн дүүргийн боловсрол соёлын газруудтай хамтран Төрийн ордны их танхимд “Оюуны элч-2016” оны шилдэг залуу багш шалгаруулах ёслолын ажиллагааг зохион байгуулахаар болжээ. Хүүхэд залуучуудын эрдэм мэдлэгт оюуны их ундаргаа харамгүй зориулж, амьдралд хөл тавих анхны алхмыг чиглүүлж өгдөг багш хэмээх ариун үйлстнийг алдаршуулан урамшуулах зорилгоор зохион байгуулж байгаа уг ёслолын ажиллагааг БСШУСЯ-тай хамтран зохион байгуулж Монголын залуу багш нарын холбооны “Оюуны од“ цол тэмдэг, Монголын Залуу Багш нарын Холбооны “Оюуны элч” цомыг олгох юм байна. Энэ талын дэлгэрэнгүй мэдээллийг www.mminfo.mn сайтаас авна уу.

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

# Д.ЭРДЭНЭБАТ:

## НАМЫН ДАРГАА НИЙТ ГИШҮҮДЭЭРЭЭ СОНГОНО ГЭДЭГ ФРАКЦГҮЙ БОЛЖ БУЙН ТОД ЖИШЭЭ




**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Өнөөдрийн энэ хурлаар юуг шийдэж байна вэ гэвэл ирээдүйн хөгжлийн энэ чиг хандлага руугаа зөв үзэл баримтлалтай, зохион байгуулалттай орохын тулд хамгийн эхэнд юу хийх юм бэ гэдэг эхний алхамыг энэ их хурлаар ойлголцъё. Тийм учраас энэ удаагийн дүрмийн шинэчлэл зөвхөн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд явах нь зөв. Өөрөөр хэлбэл, АН нээлттэй нам болох хамгийн анхны алхамаа хийж байна. Тухайлбал, намынхаа даргыг нийт гишүүдээсээ сонгож, намынхаа бүтэц зохион байгуулалтаа дахиад шинээр зохион байгуулъя гэж байгаа. Ер нь бол намын даргаа нийт гишүүдээрээ сонгоно гэдэг нь фракцигүй болж байгаагийн хамгийн тод жишээ юм. Өөрөөр хэлбэл, нийт гишүүдээсээ сонгогдсон намын дарга хэн нэгний нөлөөлөлд автахгүй байх бүрэн эрх нь хэрэгжих бололцоо нь үүснэ. Энэ хүрээнд намыг тогтвортой удирдах боломж нь цааш үүсээд явна.

**-Намын даргын асуудал ярихгүй байна гээд бухимдаж байгаа гишүүд олон байх шиг байна?**

-Манай гишүүдийн зарим нь бухимдаж байгааг буруутгахгүй. Бүх юмаа шийдээд гарчихъя гэж боддог, нуулгүй хэлэхэд өдөөдөг хэсэг ч бий. Тэр болгон руу бид алхахгүй. Одоо энэ Их хурлын дараа намын даргын марафон явж дуусаад шинэ намын дарга сонгогдсоны дараа шинэчлэлийнхээ процессыг, үзэл баримтлалынхаа шинэчлэлийг шинэ намын даргын манлайлал дор хийх ёстой. Энэ шинэ намын дарга яаж харагдах вэ гэхээр бүх намынхаа гишүүдийг төлөөлж байгаа болохоос биш аль нэгэн хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашгийг хамгаалсан ийм шинэчлэл рүү авч орж болохгүй юм шүү гэдгийг л өнөөдөр бид хийгээд байгаа юм. Тийм учраас хаа, хаанаа зөв ойлгох ёстой.

**-Фракцигүй болно гэж хэллээ. Чадах болов уу?**

-Нэг хүнийг тойрсон эрх ашгийн нэгдэл битгий байгаасай. Үүн дээр манай намынхан бүгдээрээ санал нэгтэй, маргалдах юм байхгүй байгаа. Цаашдаа энэ нам дотор үзэл бодлынхоо бодлогыг хэрэгжүүлэхийн тулд хэсэг бүлгээрээ нэгдэх, тэрийгээ лоббидох энэ хэмжээний зүйл аль ч намд байдаг, ийм эрүүл байгаасай гэж бодож байна. Тиймээс дүрмийн нэмэлт өөрчлөлтөд орж байгаа нэг алхам нь шинээр байгуулагдах Үндэсний зөвлөлдөх хороо /ҮЗХ/, дунд шатны намын хороодууд намын даргаас үл хамааралтай болно. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн хугацаанд ҮЗХ хуралдах бүрийд намын дарга ярьдаг байлаа. ҮЗХ нь намын даргыг огцруулах ч эрхтэй, томилох ч эрхтэй. Шинэ дүрмийн өөрчлөлтөөр нийт гишүүдээр сонгогдсон намын даргыг ҮЗХ-ны хуралдаанаар хэлэлцээд огцруулах тухай ярих эрхгүй болно. Шинээр сонгогдох ҮЗХ бодлогын асуудлаа л ярина. Үүгээрээ том алхам хийж байгаа юм.

**-Их хурлыг өчигдөр /өнгөрсөн мягмар гарагт/ хаалттай горимд шилжүүлсний дараа танай намын зарим гишүүн “Ийм ардчиллын төлөө яваагүй, намаасаа гарлаа” гэдгээ мэдэгдсэн байсан. Яагаад АН гишүүдээ алдаад байна вэ?**

-АН гишүүдээ алдаж байна гэж би үзэхгүй байгаа. 1210 гишүүнийг та бүхэн харж байгаа, энд Монголын жирийн иргэдийн төлөөллүүд бий. Би тэднээр бахархдаг. Энд зангиатай орж ирээд том, том ярьдаг хүн цөөхөн. Жирийн иргэдийг төлөөлсөн энэ гишүүд маань АН-ыг тарчаасай, бутарчаасай гэж бодож энд ирсэн гэж бодохгүй байна. Ер нь АН-ын гишүүд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсээр ирсэн, цаашдаа ч байна. Энэ асуудал дээр эмзэглэх юм байхгүй. Цаашдаа өөрсдийгөө аваад явах чадвартай байх ёстой гэдэг дээр л бид санал нэгдэх ёстой.

**-ҮЗХ-ноос намын даргад хариуцлага тооцох хэрэггүй гэж үзсэн. Гэтэл Н.Алтанхуяг гишүүн Засгийн газраа унагасан хүмүүст хариуцлага тооцох хэрэгтэй гээд байна. З.Энхболд дарга ирэх гуравдугаар сар хүртэл АН-ын дарга хэвээрээ байна гэсэн үг үү?**

-Намын дарга огцорсноор, нэг хүн намаас гарснаар, нэг хүн нөгөөдөө хариуцлага хүлээлгэдэг байснаар асуудал шийддэг байсан бол маш олон зүйлийг шийдэх байлаа. Энэ бол бидний тулгамдсан асуудал биш юм байна гэдгээ хаа, хаанаа ойлгочихлоо. Тийм учраас бид бүх юмаа дүрмийнхээ шинэчлэлийн хүрээнд хийнэ. Бид урагшаа харж ажиллах ёстой. Өнгөрсөн амьдралд гарсан алдаа, дутагдлыг давтахгүйн тулд бид бүх юмаа цоо шинээр эрүүлээр харж, хамтын шийдвэрээ гаргах ёстой. Энэ бол бидний тулгамдсан асуудал. Өнөөдрийн VI Их хурал бол тулгамдсан асуудлын шийдлийн хамгийн эхнийхийг тавьж чадах бүрэн бололцоотой л гэж харж байна.

> ...Энэ бол бидний тулгамдсан асуудал биш юм байна гэдгээ хаа, хаанаа ойлгочихлоо. Тийм учраас бид бүх юмаа дүрмийнхээ шинэчлэлийн хүрээнд хийнэ...

БАЙНГЫН ХОРОО

# А.СҮХБАТ: Туул голыг шинжлэхэд хүнцэл, мөнгөн ус маш их хэмжээгээр илэрсэн

Ж.МЯГМАР

УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. УИХ-ын гишүүн А.Сүхбат, Туул голын бохирдлын асуудлаар ирүүлсэн өргөдлийн дагуу холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Энэ үеэр Туул голын хурдасаас авч шинжлэхэд хүнцэл, мөнгөн ус маш их хэмжээгээр илэрч байсан. Саяхан нэг иргэн 400 кг мөнгөн ус авч яваад баригдсан талаар мэдээлэл гарч байна. Хэлэлцэж буй үндсэн чиглэлийн төсөлд Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн төсөл багтаж байгаа юм байна. Хуульд химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, худалдах ашиглахад тагнуулын байгууллагын хяналт, оролцоог нэмэгдүүлэх, химийн хорт болон аюултай бодисын эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор тусгажээ. Тагнуулын байгууллагын оролцоог хэрхэн нэмэгдүүлэх вэ хэмээн асуусан. Харин УИХ-ын гишүүн Б.Батзориг, газар тариалангийн компаниуд хөрс хамгаалах бодис оруулж ирэхийн тулд салбарын яамнаас гадна ХЗДХЯ, МХЕГ гэх мэт байгууллагаас зөвшөөрөл авдаг. Дээр нь тагнуулын байгууллага нэмэгдэх нь. Хүнд суртал улам нэмэгдэх биш үү гэлээ. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын зөвлөх Ц.Шийрэвдамбын хариулснаар, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийг 2006 онд шинэчлэн баталж химийн болон хорт бодисын ангиллыг олон улсын жишигт нийцүүлсэн аж. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Тагнуулын байгууллагын санаачилгаар Засгийн газраас боловсруулж буй аж. Химийн хортой болон аюултай бодисын үр дагавар их учир эдгээрийг экспортлох, импортлох, худалдах, ашиглахад тагнуулын байгууллага оролцохоос өөр аргагүй гэж Засгийн газар үзэж буй юм байна. Химийн хортой болон аюултай бодисыг хулгайн замаар 30-40 тонноор ч оруулж ирэх явдал гарч буй учир үүнд дан ганц Мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавих боломжгүй гэж үзсэн ажээ. Дараа нь гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар санал хураалт явуулсан бөгөөд Байнгын хорооны санал, дүгнэлтээ.

### НДҮЗ-ийн гишүүдийг томилоход хууль зөрчихгүй байхыг сануулав

УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол соёл, шинжлэх ухааны байнгын хороогоор Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох асуудлыг хэлэлцэх үеэрээ Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооноос санал болгосон хоёр төлөөллийг хасч Монголын Ахмадын холбоо, мөн ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг “Монгол даатгал” ХХК-ийн төлөөллийг дэмжсэн байна. Энэхүү томилгоог Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо эсэргүүцэж буйгаа мэдэгдэж мэдэгдэл гаргажээ. Тус холбооны мэдэгдэлд “Энэхүү томилгоо нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.2-т “Даатгуулагчийг төлөөлж нийт ажилтны дийлэнх олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг төлөөлөн хамгаалсан үйлдвэрчний эвлэлийг төлөөлсөн гурван хүн” гэсэн заалтыг зөрчсөн байна. Иймд дээрх хуулийн заалтыг баримтлан нийт хөдөлмөрчдийн эрх ашгийг хангаж ажиллахыг хүсэж, УИХ-ын дарга М.Энхболд, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан, УИХ-дахь намын бүлгүүдийн дарга нарт хүргүүлжээ.

### Байнгын хороодын ирц бүрдсэнгүй

Төрийн байгуулалт болоод Эдийн засгийн байнгын хороо 09.00 цагаас хуралдах ёстой байсан ч ирц хүрээгүй тул тус тус хойшлогдлоо. Тус байнгын хороогоор “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, санал дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх ёстой байсан юм. Түүнчлэн Эдийн засгийн байнгын хороогоор Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилт, барилгын салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудын талаархи Барилга, хот байгуулалтын сайдын мэдээллийг сонсох, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын өр, зээлийг барагдуулж, ашигт ажиллагааны төвшинг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн болон 2017 онд хувьчлагдах обьектуудын хувьчлалын бэлтгэл ажлын явц, байдал, тулгамдсан асуудлуудын талаархи Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын мэдээллийг сонсох хуваартай байсан юм.

ШАР МЭДЭЭ

## Сундуй, Сандуй нарын ээлжит дуулиан дэгдлээ





Ж.ӨӨДЛӨН

“Нийслэлийн Сундуй, Сандуй” гэх нэрээр танил болоод буй Нийслэл хотын захирагч бөгөөд Улаанбаатар хотын дарга С.Батболд, НИТХ-ын дарга Ц.Сандуй нарын “шоу”-ны шуугиан тасрахгүй шинжтэй. Хэдхэн хоногийн өмнө “Хар сарнай” хамтлагийн дуучин С.Амармандах тэдний зохион байгуулсан, байгуулаагүй гэх “Аз жаргалтай Улаанбаатар” цэнгүүнд оролцож, дуулсны дараа ОХУ-ын дипломатчид зодуулж, хүнд гэмтэн нийгэмд томоохон дуулиан дэгдээсэн. Одоо ч шуугиан нь намжаагүй л байгаа. Гэтэл өчигдрөөс Нийслэлийн Сундуй, Сандуй “Төсөв батлагдсаны баяр” хийсэн гэх бас нэг цэнгүүний урилга цахим ертөнцөд тарж эхлэх нь тэр. Зарим интернэт хэрэглэгчдийн хувьд урилгыг эвлүүлэг, фотошоп хэмээн тайлбарлах аж. Гэхдээ л цэнгүүний урилга үнэн эсвэл худлаа байлаа ч нийслэлийн удирдлагууд шоуны дуулианаас мөддөө л салахгүй нь бололтой.

МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

## ҮЗЭЛ БОДОЛ

# АН-ЫГ "ХОВ, ХОР, ХОГ" ГУРВААСАА САЛСАН ЭСЭХИЙГ ЦАГ ХУГАЦАА Л ХАРУУЛНА



**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

### МАН–ы хурал уу, АН–ы хурал уу...

УИХ-ын 2016 оны сонгуулиар МАН-д 65 суудал "бэлэглэж", бүлэг байгуулах хэмжээний суудалтай үлдсэн дарга тухайн үедээ буюу сонгуулийн шөнө Ардчилсан намын ялагдлын хариуцлагыг хүлээж, даргаасаа огцорно хэмээн мэдэгдэж байсан. Үүнээс хойш тэрбээр "ам нээлгүй" чимээгүйхэн байсан. Тиймээс ч түүний тавих илтгэл болоод хэлэх үг нь сонгуулийн ялагдал, хариуцлагын тухайд байна байх гэсэн хүлээлт хаа хаанаа байсан. Гэтэл түүний илтгэл сонгуулийн ялагдал, хариуцлагын тухай гэхээсээ илүү өөрийгөө "ялаас" мултлах гэсэн мэт, өөрийгөө өмөөрсөн аястай байсныг нуух юун. Түүний хэлж буйгаар АН-ын ялагдлын гол шалтгаан нь АН-ынхан өөрсдөө бус МАН-ынхан гэнэ. "Өрсөлдөгч нам хууль, хүчний байгууллагуудтай хамсан АН-ын гишүүдийг харлуулах ажлыг их хийсэн. Нөгөө асуудал нь сонгуулийн үед "царцааны нүүдэл"-ээс болж, Хөвсгөл, Увс, Баянхонгор, Өмнөговь зэрэг аймагт АН арав гаруйхан хүний саналаар ялагдсан. УИХ-ын сонгуулиар нэг хүний саналыг дахин дахин өгсөн ноцтой асуудал гарсан. Сонгогчдын бүртгэлийн асуудалд алдаа гарсан. Төрийн байгууллагууд нягтлах хэрэгтэй. МАН сонгуулиар мөнгө тараасан. Гэвч, хууль, шүүхийнхэн нүдээ аниад өнгөрсөн. МАН-ыг засагтаа оруулсан нь Үндсэн хуулийг өөрчлөх явдал байсан. Чингис бондыг МАН-ынхан их шүүмжилдэг. Үнэндээ Ардын намын дарга нарын баяр баясгалантайгаар тууз хайчлан нээж байгаа бүтээн байгуулалтууд Чингис бондын мөнгөөр хийж буй бүтээн байгуулалтын үр дүн юм. Тэгвэл МАН-ын ургийн мод өдрөөс өдөрт нахиалан цэцэглэж байна. Дэлхийн энхтайвны бэлгэ тэмдэг Далай багш Монголд өмнө нь ирж л байсан, явж л байсан. Энэ бүхнийг бид дипломат аргаар шийддэг байсан. Тэгсэн өнөөдөр хилийн хураамжаа нэмэгдүүлж, бүх албан ёсны хэлэлцээрээ зогсоочихоод буруутан хайж байна. МАН ажлаа хий. МАН-ын төрийн ажлын туршлагагүй, мэргэжлийн бус сайд дарга, Монголбанкны ерөнхийлөгч нар зөвхөн АН-ыг гутаан доромжилсноос болоод эдийн засаг уналтад орсон. Ийм хүмүүстэйгээ хариуцлага тооц" гэх зэргээр эрх баригчдыг ярьсаар илтгэл нь өндөрлөсөн юм. Их хурлын нээлт улс орон даяар телевизээр шууд цацагдаж байсан учир МАН-ынхан ач холбогдол өгч үзсэн нь ойлгомжтой. Харин түүний энэхүү илтгэлийг сонсоод энэ Их хурал АН-ын хурал юм уу, МАН-ын тухай ярих хурал юм уу хэмээн хошигнох хүмүүс ч олон байлаа. Түүний дараа АН-ын шинэтгэлийн хөтөлбөрийг УИХ-ын гишүүн асан Х.Тэмүүжин танилцуулснаар үдээс хойшхи хурлаа хаалттай горимд шилжүүлсэн юм. Сураг, ажиг сонсох нь ээ, Их хурлын гишүүд хаалттай хаалганы цаана нэлээд ширүүхэн үг хаялцсан гэнэ. Тухайлбал, гавьяат жүжигчин Д.Сосорбарам Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн дайсан үгийг хэлчихээд, намаасаа гарч, шинэ нам байгуулна гэж мэдэгдээд их л ууртай хурлыг орхин гарсан байгаа юм. Харин Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг АН-ын ялагдал буюу АН-ыг яаж ялагдуулсан тухай мөн ерөнхийлөгчийн талаар хатуухан үг хэлсэн байна. Тэрбээр "Манай Ц.Элбэгдорж захиалга өгдөг, зохиомол хэрэг үүсгэдэг, шалгадаг, дарамталдаг, өөрийн гэсэн мөрдөн байцаагчтай, өөрийн гэсэн прокурортой, шүүгчтэй. Гэхдээ үүнийг ганцхан Ц.Элбэгдорж хийгээгүй. МАН-тай хамтарч хийдэг. МАН-ын дарга М.Энхболд чимээгүй суучихаад, АН-ынхан л болохгүй байна, бүтэхгүй байна гээд ард нь хараад сууж байдаг" хэмээн байр суурьа илэрхийлсэн нь төлөөлөгчдийн анхаарлыг ихээхэн татжээ. Ийнхүү эхний өдрийн хурал оройн 18:00 цагт өндөрлөх ёстой байсан ч шөнийн 22:00 цагийн үед өндөрлөсөн юм. Арга ч үгүй биз, бүтэн найман жилийн дараа сая нэг юм Их хурлаа хийж байгаа учир элдэв бодсон санаснаа хэлж, ярих гэсэн гишүүд хурлаа тийм ч хурдан дуусгахыг хүсээгүй нь ойлгомжтой.

### Өнөөдрөөс орон даяар намын даргыг тодруулах сунгаа эхэлнэ

Нийслэлийн есөн дүүрэг, 21 аймгаас 1210 төлөөлөгч оролцсон АН-ын Их хурал өчигдөр 10:00 цагаас СТӨ-нд үргэлжлүүлэн хуралдлаа. Хурлын эхэнд Үндсэн дүрмийн өөрчлөлтөө танилцуулсан юм. Ардчилсан намын үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн ахлагч Ш.Түвдэндоржийн танилцуулснаар АН нь Үндсэн дүрмийн хороотой байна. Түүн дотроо Ёс зүйн хяналтын хороо, Санхүүгийн хороо багтаж ажиллах аж. Тус бүр таван хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдана. Тухайлбал, Ёс зүйн хяналтын хороогоор намын нэр хүндэд халгаатай үйлдэл хийсэн гишүүдийг хэлэлцэн, шийдвэр гаргах юм байна. Харин Санхүүгийн хороог байгуулж байгаа нь өнгөрсөн хугацаанд намын санхүүжилтийн асуудлыг намын дарга нь нуруун дээрээ үүрч, дангаараа шахам шийдэж ирсэн тул тусдаа Санхүүгийн хороотой байх нь зөв гэж үзжээ. Мөн намын даргыг сонгох сонгууль нь бүх шатанд бүх гишүүдээс санал авч байж, тодрох болж байна. Намын даргад нэр дэвшигч нь гишүүдийнхээ саналыг авах зорилгоор мөнгөн болон эд хөрөнгийн шинжтэй амлалт өгөх, гишүүдийн саналыг худалдан авахыг хориглоно. Нэр дэвшигчийн рейтинг тогтоох санал асуулга явуулах, санал асуулгын дүнг олон нийтэд зарлахыг хориглоно гэх мэтчилэн заалт тусгасан байна. Ийнхүү Их хурлаар намынхаа дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, дэмжин баталсан нөхцөлд маргаашаас /өнөөдөр/ эхлээд орон даяар намын даргыг тодруулах сунгаа эхлэх гэнэ. Улмаар ирэх гуравдугаар сард Их хурлыг дахин зарлан хуралдуулж, намын даргаа батлах юм байна. Үндсэн дүрмийн өөрчлөлтөө танилцуулсны дараа гишүүдийн ярианы сэдэв нь "Танилцах боломжийг олгосонгүй" гэх шүүмжлэл байлаа. Учир нь Их хурал эхлэхийн өмнө буюу өчигдөр л гишүүдэд намын үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийг бүрэн эхээр нь тараасан юм байна. Ийнхүү VI Их хурал түр завсарлаад буцаж орохдоо хаалттай горимоор үргэлжилсэн юм.

### Намын даргын хариуцлагатай холбоотой заалтын эрэлд...

Үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийг хэлэлцэхдээ том слайдан дээр дүрмийн төслөө гаргаад заалт заалтаар нь нухацтай хэлэлцсэн байна. Дугаар шилжих мөчид дүрэмд орох нийт есөн бүлгээс дөнгөж гурван бүлгийг хэлэлцэж, дэмжсэн гэх мэдээлэл ирсэн юм. Тухайлбал, АН-ын гишүүний татвар нэмэгдүүлэх санал олонхийн дэмжлэг хүлээсэн гэнэ. Тиймээс АН-ын гишүүдийн сарын татвар нь 1000, жилийн татвар нь 12 мянган төгрөг болжээ. Мөн намын гишүүн бүр цахим үнэмлэхтэй болох, намд шинээр элсэж байгаа гишүүн нь намын гишүүний батлахын үнийг төлөх зэрэг өөрчлөлтүүд орж байгаа юм байна.

Ийнхүү өчигдрийн Их хурлын уур амьсгал намын даргын асуудал гэхээсээ Үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийн асуудал байсан юм. Намын дүрмийг хэлэлцэх шатанд гишүүд Ш.Түвдэндоржоор ахлуулсан ажлын хэсэг дүрэм боловсруулахдаа хайнга хандаж, хариуцлагын асуудлыг орхигдуулсанд шүүмжлэлтэй хандаж байсан юм. Харин Ш.Түвдэндорж "Үндэсний зөвлөлдөх хорооноос 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй дүрмийн ажлын хэсэг байгуулсан. Гэтэл зөвхөн намайг буруутгаад байх юм" хэмээн өөрийгөө хамгаалаад авсан. Их хурлын төлөөлөгчид бухимдах болсон шалтгаан нь ажлын хэсэг дүрмийн төсөл боловсруулах шатанд багцалсан төслүүдэд оруулсан зарим заалт алга болчихсон гэнэ. Өөрөөр хэлбэл, намын дарга Их хурлаа зарлан хуралдуулаагүй тохиолдолд ямар ч маргаангүй дүрмийн дагуу намын даргыг огцорсонд тооцно гэж заасан байсан юм байх. Гэтэл өнөөх заалт нь Үндсэн дүрмээс нь алга болчихсон аж. Тиймээс ч Их хурлын төлөөлөгчид намын даргын хариуцлагатай холбоотой заалтын эрэлд мордож, "Энэ хэний хийсэн ажил вэ. Хэн энэ заалтыг санаатайгаар авав" хэмээн хэсэгтээ л буруутныг хайцгаасан. Өөр нэг маргаан дагуулсан өөрчлөлт нь бүрэн эрх нь дуусссан УИХ-ын гишүүдийг ҮЗХ шууд сонгох асуудал байв. Тодруулбал, Үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд Үндэсний зөвлөлдөх хороог татан буулгаж, шинээр дахин байгуулах нөхцөлд шууд сонгогдох гишүүдэд өнгөрсөн дөрвөн жилд УИХ-д байсан гишүүд, мөн намын дарга, удирдлагууд багтаахаар заажээ. Тиймээс энэ заалтыг "хариуцлагагүй үйлдэл" гэж Их хурлын гишүүд шүүмжилж байв. Бүрэн эрх нь дуусгавар болсон тэдгээр гишүүд дунд намынхаа нэр хүндийг навс унагасан, намаа сонгуульд ялагдалд хүргэсэн гээд хариуцлага тооцох ёстой гишүүд олон байтал, тэднийг ҮЗХ шууд сонгох нь шударга бус хэмээн үзсэн хэрэг. Ийнхүү дүрмийн шинэчлэлтэй холбоотой олон асуудал өрнөсөн юм.

Мэдээж Их хурлын эргэн тойронд сайнаасаа илүү саар асуудал олон хөндөгдөж байлаа. Тухайлбал, Их хуралд оролцохоор ирсэн төлөөлөгчдийг ирсэн цагаас нь даргын сунгаанд оролцохоо мэдэгдээд байгаа С.Эрдэнэ, Г.Батхүү зэрэг эрхмүүд хайрцаглаж хоносон, хурлын дараа Г.Батхүү Их хурлын гишүүдэд мөнгө, киноны билет тараасан гэх "бор шувуу" нисээд эхэллээ. Тэгвэл Их хурлын эхний шөнө АН-ын лидерүүд хуралдаж, намыг ялагдалд хүргэсэн нөхдүүд намын даргаар сонгогдох боломжийг бүрдүүлсэн дүрмийн заалт оруулж ирэхээр тохиролцсон, Н.Алтанхуяг "Намайг Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх хүнийг би намын дарга болгоно" гэж "томорсон" гэх зэргээр олон л өнгийн яриа гараад амжив. Уг нь энэ удаад АН-ыг их шинэчлэл хийж хов, хор, хог гурваасаа салаад шинэчлэгдэж чадах байх гэсэн хүлээлт их олон хүнд байсан байх. Гэвч их хүлээлт дагуулсан Их хурлыг өнөөх л "хов, хор, хог" гуравтайгаа л болж өндөрлөх шинжтэй. Гэхдээ яах вэ, огт хийхгүй байснаас хийж байгаа нь сайн хэрэг биз. Энэ удаагийн хурлаараа намын удирдах алба хашч байсан дарга нар, жирийн гишүүд нь хүртэл ёстой нөгөө хийгээ гартал ярьж байх шиг. Эхний өдрийн хурал шөнийн 22:00 цаг хүргэсэн юм чинь сүүлийн өдрийн хурал хэдэн цаг хүргэхийг мэдэхгүй юм. Юутай ч АН-ын Их хурлаас хүлээж байсан шинэчлэл хийгдэж чадах эсэхийг цаг хугацаа л харуулах биз ээ.

## ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Дугаарын **60** мөр

## Хувь хүний малыг тоолж, мөнгө үрэх хэрэг байна уу

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэртэй тэргүй улс орны эдийн засаг жинлүүрийн туухайн дээр дэнжигнэж байхад илүү зүйлд мөнгө зарлагадах хэрэг үнэндээ алга. Жил бүрийн арванхоёрдугаар сард мал тооллогын ажил эхэлдэг. Тэгвэл энэ жилийн мал тооллого өчигдөр орон даяар эхэлсэн. Тооллогыг 10 хоногийн хугацаанд 21 аймгийн хэмжээнд нэгэн зэрэг явуулах бөгөөд Үндэсний Статистикийн хорооноос баталсан зааврын дагуу мал, тэжээвэр амьтдыг нүдээр үзэж нэг бүрчлэн тоолохыг тооллогын комисст үүрэг болгосон байх юм. Тооллогын комиссыг аймгийн Засаг дарга нар ахлаж, Статистикийн хэлтэс, ХХААГ, Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга нар явуулах юм байна. Манай улс өнгөрсөн оны намар 65 сая гаруй мал тоолуулсан байдаг. Үүнээс өвөл хүнсэнд 10 сая орчмыг нь хэрэглэж, өвлын тооллогоор 56 сая болж байсан юм. Мал тооллогын дүнгээр нийт тоологдсон малын 98.2 хувийг амины мал эзэлж байсан байна хэмээх тоо баримтыг энэхүү нүсэр ажлын дүнд гаргадаг. Энэ тоо баримт хэнд хэрэгтэй юм бэ. Өнөөдөр бидний амьдралд бодит ашгаа өгч байгаа бил үү. Хатуухан хэлэхэд үгүй. Харин ч бидний өгсөн татварын мөнгө 10 хоногийн хугацаанд л агаарт хийсч, цацагдаж байна. Нэг жишээ дурьдахад л, Дундговь аймагт тооллогын хяналтыг хийхэд 2.4 сая гаруй төгрөг шаардлагатай. Уг мөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахаар болсон гэнэ. Баянхонгор аймагт бүр гурван сая гаруй төгрөгийг 2016 оныхоо төсөвт суулгасан байх жишээтэй. Эндээс бяцхан тооцоо хийж үзье. Аймаг бүр 2-3 сая төгрөгийг мал, тэжээвэр амьтдыг тоолох ажилд зарцуулж байна гэвэл 42-63 сая төгрөгийг зарцуулж байгаа юм. Улс оронд ч, хувь хүнд ч хэрэггүй ажлыг жил бүр олон сая төгрөг гарган хийж байхаар больсон нь дээр биз дээ. Энд улсын төсөв гэх сүрхий нэр явж байгаа хэдий ч цаана нь ард иргэдийн татварын мөнгө л явж байгаа шүү дээ, үнэндээ. Үүнийхээ оронд хүнээ тоолж, өрхийн амьжиргааны судалгаагаа хийгээсэй билээ. Монгол Улсын хүн амын 27.4 хувь нь ядуу амьдардаг гэсэн судалгаа бий. Тодруулбал, сумтай харьцуулахад нэг сум дунджаар 4-5 мянган хүн амтай гэж үзвэл Монгол Улсын 160 сумтай тэнцэх хэмжээний иргэд ядуу амьдарч хоногийнхоо хоолыг өлмөн зэлмүүн залгуулж байна гээд хатуухан хэлчихвэл хэтийдэхгүй. Хотод ядуурлын үзүүлэлт хүн амын 23.2 хувьтай тэнцэж байсан бол хөдөөд 35 хувьтай тэнцэх дайны иргэн ядуу буюу өдөрт авах хоол хүнснийхээ илчлэгийг авч чадахгүй байгаа судалгаа байгаа юм. Энэ мэтчилэн шийдлээ хүлээсэн тоо томшгүй олон асуудал буцалж байхад заавал мал, тэжээвэр амьтан тоолоход улсын төсвөөс 63 сая төгрөг гаргах хэрэггүй баймаар юм. Түүнийхээ оронд нэг иргэнийхээ хоол хүнсний илчлэгийг нэмэгдүүлэхэд, нэг залуут ажлын байртай болгоход, нэг хүүхдийг хичээлээ тараад гэрэлтэй гудамжаар гэртээ харихад зарцуулмаар юм даа. Яах вэ дээ, Мэргэжлийн Засгийн газар нэгэнт л хэрэггүй урсгал зардлуудаа танана гэсэн юм чинь энэ мэтчилэн улсын мөнгийг үр ашиггүй зүйлд зарцуулаад байгаа ажлуудаа зогсоочих хэрэгтэй шүү дээ.

## УЛС ТӨР

АЙЛЧЛАЛ



# ОХУ-Д 433 ХҮҮХЭД ТЭТГЭЛГЭЭР СУРАЛЦУУЛАХААР БОЛЖЭЭ

Ж.МЯГМАР

БСШУС-ын сайд Ж.Батсуурь өнгөрсөн арваннэгдүгээр сарын 28-аас арванхоёрдугаар сарын 02-ны өдрүүдэд ОХУ-д албан ёсны айлчлал хийлээ. Тэрбээр ОХУ-аас гansзага дүүрэн ирсэн байна. Тиймээс ч айлчлалын үр дүнгийн талаар өчигдөр мэдээлэл хийлээ. Тус айлчлалын хүрээнд ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёл, спортын сайдтай албан ёсны уулзалт хийж, хоёр улсын салбарын хамтын ажиллагааг шинэ төвшинд гаргажээ. Мөн ОХУ-ын Соёлын сайд В.Р.Мединскийгийн урилгаар ОХУ-ын Санкт-Петербург хотноо болсон “Олон улсын соёлын V чуулга уулзалт”-д оролцож, хоёр улсын соёлын салбарт хамтран ажиллах санамж бичгийг үзэглэсэн байна. Айлчлалын хүрээнд арваннэгдүгээр сарын 29-ний өдөр ОХУ-ын Соёлын сайд В.Р.Мединскийтэй албан ёсны уулзалт хийжээ. Уулзалтын үеэр дараах соёлын салбарт дараах чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиролцжээ. Тодруулбал, хоёр улсын киноны өдрүүдийг 2017 онд харилцан зохион байгуулах, Монгол Улсын Хөгжим бүжгийн дунд сургуулийг Хөгжмийн их сургууль болгон өргөжүүлэхэд ОХУ-ын тал дэмжлэг үзүүлэх, хоёр улсын сонгодог хөгжмийн тоглолтыг харилцан зохион байгуулахаар болжээ. Түүнчлэн хоёр улсын соёлын өдрүүдийг 2018 онд өргөн цар хүрээтэйгээр харилцан зохион байгуулах, ОХУ-ын Төв номын сан Монгол Улсын Төв номын сан хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцсон байна.

> ...Хамтын ажиллагааны 10 жилийн ойг тохиолдуулан хамтарсан олон улсын хурал зохион байгуулах, Хоёр улсын Шинжлэх ухааны академийн хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцжээ. Мөн палентологи, геологи, биологийн хамтарсан экспедицийг үргэжлүүлэн хэрэгжүүлэх, Монгол Улсын залуу судлаачдыг ОХУ-ын Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдэд хамтарсан судалгаа хийлгэх, дадлагажуулах, сургалтад хамруулахаар болжээ...

### ОХУ-ын дасгалжуулагч нар манай улсад гэрээгээр ажиллана

БСШУС-ын сайд Ж.Батсуурь ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын I орлогч дарга, ОХУ-ын Олимпийн хорооны Ерөнхийлөгч А.Д.Жуков, Төрийн Думын Биеийн тамир, спорт, аялал жуулчлал, залуучуудын байнгын хорооны дарга М.В.Дегтярев нартай арваннэгдүгээр сарын 29-нд, ОХУ-ын Спортын сайд П.А.Колобковтой арваннэгдүгээр сарын 30-ны өдөр тус тус уулзжээ. Улмаар хоёр улсын биеийн тамир спортын салбарын хамтын ажиллагааны асуудлаар санал, мэдээлэл солилцсон байна. Уулзалтын үеэр спортын салбарт дараах чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиролцоэ чаджээ. Тодруулбал, Спортын салбарт хамтран ажиллах санамж бичигт 2017 оны долдугаар сард гарын үсэг зурах, хоёр улсын Үндэсний шигшээ багуудын хамтарсан бэлтгэл цугларалтыг 2018 оноос ээлжлэн зохион байгуулахаар харилцан тохиролцжээ. Мөн ОХУ-ын өндөр зэрэглэлийн дасгалжуулагчдыг манай улсад гэрээгээр ажиллуулах, Монгол Улсын Үндэсний шигшээ багийн дасгалжуулагчид, төрийн байгууллагын болон спортын холбоодын мэргэжилтнүүдийг ОХУ-ын Спортын яамны харьяа Сочи хотын Олимпийн академид давтан сургах, мэргэшүүлэхээр болсон байна. Түүнчлэн ОХУ-д өвлийн болон багийн спортын дасгалжуулагчаар сургах оюутны тоог нэмэгдүүлэх, Монгол Улсад 2020 онд зохиогдох “Азийн хүүхдийн спортын наадам”-д шаардагдах төсөвт дэмжлэг үзүүлэхээ илэрхийлжээ.

### 2017–2018 оны хичээлийн жилд ОХУ–д 433 хүүхэд тэтгэлгээр сургана

Айлчлалын хүрээнд салбарын сайд арваннэгдүгээр сарын 29-ний өдөр ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны сайд О.Ю.Васильеватай уулзлаа. Мөн энэ өдөр ОХУ-ын Россотрудничество агентлагийн дэд дарга Г.Д.Юрьевичтай албан ёсны уулзалт хийжээ. Энэ хүрээнд боловсролын салбарт дараах чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиролцсон байна. Тодруулбал, 2017-2018 оны хичээлийн жилд ОХУ-д 433 хүүхэд тэтгэлгээр сургах, ОХУ-ын соёл, урлагийн чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуульд элсэн суралцах Монгол иргэдийн сонгон шалгаруулалтыг 2017 оноос Монгол Улсад зохион байгуулахаар болжээ. Мөн Монгол Улсад ОХУ-ын сургалтын хөтөлбөрөөр сургалт явуулдаг, ОХУ-ын ерөнхий боловсролын гэрчилгээ хүлээн авдаг ерөнхий боловсролын сургууль (ОХУ-ын Элчин сайдын яамны дэргэдэх сургууль, Плехановын нэрэмжит сургууль, Эрдэнэтийн сургууль, Орос-Монголын хамтарсан III сургууль) төгсөгчдийн төгсөлтийн ерөнхий шалгалт авах төвийг МУБИС-д түшиглэн байгуулахаар болсон байна. Түүнчлэн эдгээр сургууль төгсөгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын дүнг үндэслэн ОХУ-ын их, дээд сургуульд үнэгүй суралцуулах, Орос хэлний сургалтын төвийг ОХУ-ын М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн Их Сургуулийн дэмжлэгээр МУБИС-д байгуулахаар болсон аж. Орос хэлний бэлтгэл анги нээж хичээллүүлэх, Орос хэлний багшийн мэргэжил дээшлүүлэх зуны сургалтыг ОХУ-д зохион байгуулахаар болжээ.

### Залуу судлаачдыг ОХУ–д судалгаа хийх боломжоор хангана гэв

Айлчлалын хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам ОХУ-ын “Суурь судалгааны сан”-гийн хооронд хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Энэ хүрээнд био анагаах, газар зүй гэсэн тэргүүлэх чиглэлүүдээр дараах арга хэмжээг зохион байгуулахаар харилцан тохиролцов. Үүнд, Хамтын ажиллагааны 10 жилийн ойг тохиолдуулан хамтарсан олон улсын хурал зохион байгуулах, Хоёр улсын Шинжлэх ухааны академийн хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцжээ. Мөн палентологи, геологи, биологийн хамтарсан экспедицийг үргэжлүүлэн хэрэгжүүлэх, Монгол Улсын залуу судлаачдыг ОХУ-ын Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдэд хамтарсан судалгаа хийлгэх, дадлагажуулах, сургалтад хамруулахаар болжээ.

МM-ИЙН ТОДРУУЛГА

## О.Алтансүх: Залуу хүн бүр ирээдүйнхээ өмнө сэтгэлгээний хувьсгалыг эхлүүлэх үүрэг хүлээж байна

Э.ТУУЛ

*Монгол Улсыг залуучуудын орон хэмээдэг ч өнөөдрийг хүртэл энэ асуудлыг хариуцсан тусгайлсан агентлаггүй явж ирсэн билээ. Харин шинэ Засгийн газар байгуулагдсанаар залуучуудын асуудлыг хариуцсан тусгайлсан агентлагийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нэртэйгээр байгуулаад удаагүй байна. Энэ агентлагийг удирдахаар томилогдоод байгаа О.Алтансүхээс зарим зүйлийг тодрууллаа.*

**-Залуучуудын хөгжил болон тэдний өмнө тулгардаг олон асуудлыг төрийн бодлогоор зохицуулах тусгайлсан агентлаг байгуулагдлаа. Нийт хүн амын 35 хувийг эзэлж буй залуучууд руу чиглэсэн ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ?**

-Өмнө нь залуучуудын асуудал зөвхөн салбар дундын зохицуулалтаар хэлэлцэгдэж, шийдэгддэг, тусгайлан хариуцсан төрийн байгууллага байсангүй. Харин энэ удаагийн УИХ, Монгол Улсын Засгийн газар түүхэндээ анх удаа гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр ажиллах агентлаг байгуулах шийдвэрийг гаргасан. Манай байгууллага бол хэрэгжүүлэгч агентлаг. Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт зөвхөн залуучуудын эрүүл мэнд, орон сууц, ажлын байр зэрэг тулгамдсан асуудлыг шийдэх талаар зургаан томоохон зорилтыг тусгасан. Энэ бол Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хамгийн чухал хийх ажил. Өөрөөр хэлбэл, залуучууд руу чиглэсэн эрүүл мэндийн ямар бодлого баримтлах, ажлын байртай холбоотой ямар дэмжлэг үзүүлэх вэ гэх мэт Засгийн газраас санаачилсан бодлогуудыг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч ажиллах болно. Мөн залуучуудыг өөрсдөөсөө шалтгаалж нийгмээ өөрчлөх эерэг хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр идэвх зүтгэл гаргаж ажиллана. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан залуучуудын чиглэлээр хийх зорилт нь манай агентлагийн хийх ажил, газрын зураг гэж ойлгож болно.

**-Залуучууд маань удахгүй бие даасан хуультай болох талаар Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанаас мэдээлсэн. Энэхүү хуулийн ач холбогдол, зорилгын талаар танилцуулахгүй юу?**

-Энэ бол Монголын залуучуудын томоохон байгууллага НАМЗХ-ны санаачилга, зүтгэл гэж болно. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр энэ асуудлыг санаачлан 21 аймаг, олон арван сумдад хэлэлцүүлэг хийж залуучуудын саналыг тусгаж, 2012-2016 оны УИХ-д өргөн барьсан байдаг. Гэвч хэлэлцэж амжаагүй. Харин одоо манай салбарын сайдын ажлыг аваад энэ ажлаа үргэлжүүллээ. Хуулийн төсөл Засгийн газраар дэмжигдсэн, удахгүй УИХ-аар хэлэлцэж эхэлнэ. Хуулийн төсөлтэй холбоотой хэлэлцүүлэг болон УИХ-д өргөн барих бэлтгэл ажлууд үргэлжилж байна. Нэг зүйлийг онцлоход энэхүү хууль нь халамжийн бус хөгжлийн хууль байх юм. Хуулийн гол зорилго нь залуучуудын хөгжлийг дэмжих тэдний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, идэвх оролцоог сайжруулах, хариуцлагатай залуу иргэнийг төлөвшүүлж, тэднийг дэмжихэд чиглэнэ. Мөн тэдэнд эх орон ч үзлийг төлөвшүүлэх дорвитой ажил хийгдэх юм. Үүнээс гадна “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай сан” байгуулна. Энэхүү сангаар дамжуулан залуучуудыг тодорхой бизнес эрхлэх, эрүүл мэнддээ анхаарах, хамтран амьдрах хэв маягт суралцахад нь зориулж тодорхой төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх үзэл санаа туссан.

**-Залуучуудын хөгжил өөрсдийнх нь хариуцлага, хүчин чармайлтаас шалтгаална. Тэдэнд хандаж юу хэлэх вэ?**

-Ёстой загатнасан газар маажлаа гэдэг шиг үг хэллээ. Залуучуудын хариуцлага, ухамсар нь тэдний, цаашлаад нийгмийн хөгжлийн гол эргэлтийн цэг болох үедээ байна. Бид сайн эцэг, эх байж үр хүүхдээ хайрлаж, эрүүл хүн болгон өсгөж, зөв хүн болгож хүмүүжүүлэх нь улс эх орныхоо өмнө хүлээх иргэний журамт үүрэг гэдгээ ухамсарлая. Гэтэл төлөвлөөгүй гэрлэлт, салалт, үр хөндөлт, гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нь залуус бидний сэтгэлгээний, хариуцлагын үнэн дүр төрхийг харуулдаг. Энд тоо баримт дурьдахыг урьтал болгосонгүй. Бүгдээрээ л мэдэж, сэтгэл нь зовниж байгаа. Гэхдээ бүгдийг бусдаас нэхэх биш бид өөрчилж чадна гэсэн хандлага, бодитой санаачилга ус агаар шиг хэрэгтэй байна. Цалин багатай байгаа нь гэр бүл салах шалтгаан, ажилгүй байгаа нь эхнэр хүүхдээ хүчирхийлэх нөхцөл гэж тайлбарлаж болохгүй биз дээ. Тиймээс залуу хүн бүр эх орныхоо өмнө сэтгэлгээний хувьсгал хийх үүрэг хүлээж байгаа гэдгээ ухамсарлаасай.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## ХЗДХЯ, ОХУ-ын Дотоод хэргийн яамтай хамтрахаар боллоо

Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт ОХУ-ын Дотоод хэргийн сайд Владимир Александрович Колокольцевтэй уулзлаа. Уулзалтын эхэнд С.Бямбацогт өнгөрөгч намар Улаанбаатар хотноо болсон хил орчмын бүсийн хамтын ажиллагааны асуудлаарх хамтарсан Ажлын хэсгийн хуралдаанд ОХУ-ын талаас өндөр түвшний төлөөлөгч оролцуулсанд талархал илэрхийллээ. Мөн ОХУ-ын Дотоод хэргийн яам Монгол Улсын дотоод хэргийн салбарын албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх боломж олгож, өөрийн харьяа сургуулиудад бакалавр, магистр, адъюнктурт суралцуулж байгаа явдалд талархсанаа хэллээ. ОХУ-ын Дотоод хэргийн сайд Владимир Александрович Колокольцев тус яамны эрхлэх асуудлын хүрээнд ОХУ-ын Мансууруулах бодисын эргэлтэд хяналт тавих Холбооны алба хамаардаг болсныг дуулгаад Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам ОХУ-ын Мансууруулах бодисын эргэлтэд хяналт тавих Холбооны алба хооронд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис болон тэдгээрийн түүхийн эдийн хууль бус эргэлттэй тэмцэх тал дээр хамтран ажиллахаар тохиролцов. Сайд нарын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хамтын ажиллагааг улам бүр өргөжүүлэх нь чухал ач холбогдолтой болохыг хоёр тал онцлон тэмдэглэв. Уулзалтын төгсгөлд ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт ОХУ-ын Дотоод хэргийн сайд Владимир Александрович Колокольцев нар ирэх гурван жилд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурсан байна.



## 2017 онд 83 арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ гэв

БОАЖ-ын сайд Д.Оюунхорол, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нар хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа. Улаанбаатар хотын хувьд хүрээлэн буй орчны бохирдол, доройтол тулгамдсан асуудал болсон.Иймээс Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбарын зорилтууд болон нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт мөн чиглэлээр туссан асуудлуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхээр 2017 онд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа. БОАЖ-ын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын хооронд байгуулж буй “Хамтран ажиллах гэрээ”-ний хавсралтаар баталгаажих төлөвлөгөөнд байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын зорилтыг хангах чиглэлийн хүрээнд 19 зорилтын дагуу 83 арга хэмжээг 2017 онд хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Гэрээнд гарын үсэг зурах үед БОАЖ-ын сайд Д.Оюунхорол нийслэлд тулгамдаад байгаа агаар, ус, хөрсний бохирдлын талаар мэдээлэл өгөв.

## ЦАГ ҮЕ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# “БИЧИЛ УУРХАЙГ АЛБАЖУУЛАХАД ТАЛУУДЫН ОРОЛЦОО” ЧУУЛГАН БОЛОВ




Н.БАТЗАЯА

Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл хамтран “Бичил уурхайг албажуулахад талуудын оролцоо” сэдэвт үндэсний чуулга уулзалтыг өчигдөр Чингис зочид буудалд зохион байгууллаа. Тус чуулганд УУХҮЯ, БОАЖЯ, ХНХЯ, ЭМЯ, Хүний эрхийн үндэсний комисс, болон Ашигт малтмалын газрын тосны газар, Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар зэрэг Засгийн газрын агентлагууд, аймаг, сумдын удирдлага, холбогдох албан тушаалтан, судалгаа шинжилгээний болон иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын байгууллагууд, Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, бичил уурхайчид болон бичил уурхайн ТББ-ын төлөөлөл нийт 200 гаруй хүн оролцов. Энэхүү чуулган нь бичил уурхайг зохион байгуулах, албажуулах үйл ажиллагаанд талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар бичил уурхайг албажуулах үйл явцыг эрчимжүүлэх, бичил уурхайгаар олборлосон эрдэс баялгийнборлуулалтынсүлжээг албажуулах талаар хэлэлцэж шийдэл олох зорилготой ажээ. Чуулганаар бичил уурхайг зохион байгуулах, албажуулах үйл явц болон эрдэс баялгийн борлуулалтын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх талаар бодлогын санал, зөвлөмжийг гаргасан юм. Мөн чуулганы үр дүнд бичил уурхайг заохион байгуулах, албажуулах талаархи төв болон орон нутгийн төрийн байгууллагууд, бичил уурхайчдын үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирна гэж зохион байгуулагчид үзэж байгаа ажээ. Бичил уурхайг зохион байгуулах, албажуулах, хариуцлагатай бичил уурхайг төлөвшүүлэхэд аймаг, сумдын нутгийнзахиргааныболоноөрөө удирдах байгууллага чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс тус чуулганд орон нутгийн сонгуулийн дараа шинээр сонгогдсон, томилогдсон орон нутгийн удирдлагуудыг түлхүү урьж оролцуулсан бөгөөд бичил уурхайн эрх зүйн орчин, түүний хэрэгжилт, хариуцлагатай бичил уурхайн талаархи ойлголт, бичил уурхайг албажуулж чадвал өрх гэр, орон нутаг, улс орны эдийн засагт хэрхэн хувь нэмэр оруулах боломжтой талаар мэдээлэл өгсөн. Мөн хууль бус олборлолтыг хэрхэн шийдвэрлэх, бичил уурхайгаар олборлосон эрдэс баялгийн борлуулалтыг хэрхэн албажуулах талаар хэлэлцлээ. Энэ үеэр хуралд оролцогчидтой уулзаж, бичил уурхайн эрхлэлтийг тойрсон асуудлын талаар цөөн хором ярилцлаа.

### М.Энхжаргал: Ашиглалтын 1253, хайгуулын 3000 орчим тусгай зөвшөөрөл олгосон

*/Ашигт малтмал, газрын тосны газрын орлогч захирал/*

-Ашигт малтмал, газрын тосны газар маань өнгөрсөн долдугаар сарын 28-нд шинэчлэгдэн байгуулагдаад Ашигт малтмал, газрын тосны хамт олон болсон. Манайх 12 хэлтэстэй их нүсэр агентлаг болсон. Өнөөдрийн чуулга уулзалт, бичил уурхай эрхэлж байгаа уурхайчдад тулгарч буй асуудал. Цаашид шийдэх шийдлүүдээ төрийн болон хэрэгжүүлэгч агентлагуудад тавьж байна. Мөн төр засаг агентлагийнхаа хэмжээнд эрх зүйн талаас нь зохицуулалт хийнэ.Хариуцлагатайгаармэдээ тайлангаа өгөх зохицуулалтыг хууль, эрх зүйн талаас хийж байна. Ашигт малтмал, газрын тосны хамт олон бичил уурхайн чиглэлээр нийт уурхайчдын эрх зүйн орчин, ирүүлж байгаа мэдээ, газар дээр нь очиж танилцдагийн хувьд зургаан илтгэлийг тавьсан. Түүнд манайхаас уул уурхай хариуцлагатай байхын тулд хувиараа ашигт малтмал олборложбайгаахоршоодмаань хариуцлагатай байж эргэх холбоог сайжруулах хэрэгтэй гэдгийг харж байна. Ингэснээр бидэнд ирж байгаа мэдээлэл үнэн зөв, бодитой байна. Ашиглалтын 1253, хайгуулын 3000 орчим тусгай зөвшөөрөл олгосон. Энэ жил шинээр тусгай зөвшөөрөл огт олгоогүй. Ер нь энэ салбарт 30 гаруй жил ажилласан туршлагаас харахад манай улсад уул уурхайн салбарыг буруугаар ойлгодог. Ерөөсөө л ухаад аваад сүйтгээд явдаг юм шиг ойлгодог. Гэтэл өнөөдөр уул уурхай тийм биш юм. Бид ашигласан газраа олборлоод, олборлосон газраа нөхөн сэргээгээд хүлээлгэн өгдөг. Бичил уурхай ч гэсэн нөхөрлөлийн хэлбэрт орж, Монголын дээвэр холбоо төрийн бус байгууллагад орсноор олборлолт хийсэн газраа нөхөн сэргээж эхэлсэн.

### Б.Алтанбагана: Тогтвортой бичил уурхай төсөл үр дүнтэй хэрэгжиж байна

*/Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн менежер/*

-Манай төсөл 2005 оноос эхэлж, хэрэгжсэн. Монгол Улсын Засгийн газар болон Щвейцарь улсын Засгийн газрын хамтарсан төсөл. Одоогоор манай төслийн дөрөвдүгээр үе шат хэрэгжиж байна.Энэхүүтөсөлихүрдүнтэй хэрэгжиж байгаа. Тухайлбал, 2005 оны үед бичил уурхайн нөхцөл байдал хүнд байсан. Бичил уурхайн эрхлэхийг хүлээн зөвшөөрдөггүй, бичил уурхай эрхлэгчдийг “нинжа” хэмээн гадуурхаж, нийгмийн ямар нэгэн үйлчилгээнд хамруулдаггүй байсан. Төслийн зүгээс төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран энэ тал дээр нэлээд арга хэмжээ авч ажилласан. Үүний үр дүнд бичил уурхайн эрх зүйн орчин бүрдсэн. Ингэснээр эдгээр хүмүүс хууль бус үйл ажиллагаа явуулахаа больсон гэсэн үг. Мөн хууль эрх зүйн орчинтой болсноор бичил уурхай эрхлэгчид өөрсдөө хариуцлагатай болж эхэлсэн. Эрүүл мэндийн даатгал, татвараа төлөхөөс гадна байгаль орчинд нөхөн сэргээлт хийсэн сайн жишээ гарч байгаа. Хүмүүсийн сэтгэхүй их өөрчлөгдлөө. Өмнө нь бичил уурхай эрхлэгчид хүмүүсээс айдаг, ичдэг байсан бол одоо үгээ хэлдэг, өөрсдийнхөө асуудлыг ярьдаг болсон. Саяны сонгуулиар гэхэд нэлээд олон бичил уурхайчид аймаг, сумын ИТХ-д нэр дэвшиж, сонгогдлоо. Энэ мэтчилэн олон сайн үр дүнгүүд гарсан.

### Ч.Алтанзаяа: 1498 хүүхэд бичил уурхайд ажилладаг

*/ГБХЗХГ-ын Хүүхэд хөгжил, хамгааллын газрын дарга /*

-Бид 2016 онд бичил уурхай эрхлэлт явагддаг 18 аймагт судалгаа явуулсан. Судалгааны үр дүнд 1498 хүүхэд бичил уурхайд ажиллаж байгаа нь тогтоогдсон. 0-18 насны хүүхдүүд гэр бүлээ дагаж, зуныхаа амралтаар ээж, аавдаа туслах гэх мэтчилэн янз бүрийн байдлаар бичил уурхайд ажиллаж байсан. Мөн 15-18 насны буюу нийт хүүхдүүдийн 80 хувь нь бичил уурхайд тогтмол ажилладаг болсон байсан. Хүүхдүүд жилийн дөрвөн улиралд уурхайд ажиллаж, ухсан нүх рүү орох, ямар ч ажлын байрны хамгаалагдах нөхцөлгүй, нийгмийн асуудал нь шийдвэрлэгдэхгүй байдалд ажиллаж, эрх нь зөрчигдөж байна. Хүүхдүүд том хүн шиг долоо хоногт 56 цаг ажиллаж байгаа ч цалингаа дутуу авдаг. Насанд хүрсэн хүн өдөрт 15-140 мянган төгрөгийн цалин авч байхад хүүхдүүд 8-15 мянган төгрөгийн цалин авч байна. Энэ мэтчилэн хүүхдийн эрх маш их зөрчигдөж байгаа. Бичил уурхайд хүүхэд амиа алдсан тохиолдол судалгааны явцад гараагүй. Гэхдээ тодорхой хэмжээгээр хөл гараа хугалж, бэртэж, гэмтсэн тохиолдол их гарсан байсан.



ЧУХАЛ ХҮН

ЗАСГИЙН ГАЗАР

# “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөрийг баталлаа

Н.ЗАЯА

*Засгийн газрын ээлжит хуралдаан өчигдөр болж, Хөгжлийн банкны талаар авах арга хэмжээ болон “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөр гэх зэрэг хэд хэдэн асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гаргалаа. Ингээд Засгийн газрын ээлжит хуралдаанаас гаргасан шийдвэрийг тоймлон хүргэе.*

## Үндэсний хөтөлбөрийг батлав

Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөртөө оюутнууд суралцах хугацаандаа цагийн ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Орлоготой оюутан” хөтөлбөр хэрэгжүүлэхээр тусгасан билээ. Тэгвэл Засгийн газрын өчигдрийн хуралдаанаар “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөрийг хэлэлцэн баталж, хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг холбогдох сайд нарт даалгалаа. Хөтөлбөрийг 2016-2020 онд хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтийг жил бүр дүгнэж байх юм. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр оюутнууд цагийн ажил, хөдөлмөр эрхлэх, ажил хөдөлмөрт бэлтгэгдэх, эзэмшиж байгаа мэргэжлээрээ дадлагажих, туршлагажих, мэргэших, төгсөөд ажлын байртай болох их, дээд сургууль, коллеж, МСҮТ, коллежууд ажлын байрны хэрэгцээ, шаардлага хангасан өндөр ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх, оюутны нийгмийн асуудлыг шийдэх, сургалт, судалгааны чанарыг дээшлүүлэх юм байна. Мөн ажил олгогчид цагийн ажил, оюутны хөдөлмөр эрхлэлтийн хууль, эрх зүйн зохицуулалттай болох зэрэг давуу тал бий болох аж. Монголын оюутны холбоо өнгөрсөн онд их, дээд сургууль, коллеж, МСҮТ-д суралцаж байгаа 15 мянган оюутны дунд судалгаа явуулсан байна. Судалгаанаас үзэхэд 10 оюутан тутмын долоо нь цагийн ажил хийх сонирхолтой гэдгээ илэрхийлжээ. Оюутнууд ажил, хөдөлмөр эрхэлж цалингаа сургалтын төлбөртөө нэмэрлэх, амьжиргаандаа зарцуулах, ажил хийж сурах, ажил, хөдөлмөрт бэлтгэгдэх боломж бүрдэнэ. Энэ бүхэн нь нийтийн тээврийн хөнгөлөлт, 70 мянган төгрөгийн тэтгэлгээс илүү ач холбогдолтой хэмээн Засгийн газар үзэж байгаа ажээ.

## Хөгжлийн банкны талаар авах арга хэмжээний тогтоолын төслийг УИХ–д яаралтай өргөн барина

Монгол Улсын Хөгжлийн банк нь 2011 онд байгуулагдснаас хойш өнөөдрийн байдлаар долоон их наяд төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байгаа юм. Мөн хугацаанд 2000 орчим төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлснээс 5.9 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Банкны нийт зээлийн багц нь актив хөрөнгийн 80 хувиас давсан, өөрийн хөрөнгөтэй нь харьцуулбал 33 дахин их байгаа нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиар зохистой харьцааны 50 дахин нэмэгдүүлсэн заалтыг зөрчихөд ойрхон байгаа юм. Хөгжлийн банк нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын гадаад зах зээлээс босгосон үнэт цаас, зээл хугацаанаасаа өмнө эргэн дуудагдах өндөр эрсдэл бий болоод байгаа. Иймд эдгээр хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцээд хууль зүйн үзэл баримтлалыг дэмжиж УИХ-д яаралтай өргөн барихаар болов. Мөн энэ үеэр Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлаар томилохыг зөвшөөрсөн. Тус банкны гүйцэтгэх удирдлагын олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцээд Б.Батбаярыг гүйцэтгэх захирлаар томилохыг Төлөөлөн Удирдах зөвлөлд зөвшөөрсөн. Б.Батбаяр нь 1998 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Санхүүч-эдийн засагч мэргэжлээр төгсөж, 2002-2004 онд АНУ-ын Индианагийн их сургуульд магистр зэрэг хамгаалсан. Сангийн яамны Төсвийн бодлогын газарт нягтлан бодогч, эдийн засагч, мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтэс, газрын дарга, Банкны өр барагдуулах алба, Төрийн банк, Хөгжлийн банк болон төрийн өмчит үйлдвэрийн газруудад төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж ТУЗ-ийн гишүүн, даргаар ажиллаж байжээ.

## Ерөнхий сайдын томилолтын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авна

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат энэ сарын 3-ны өдөр Өмнөговь аймгийн Гурвантэс суманд томилолтоор ажиллахдаа сумын иргэдтэй уулзан, санал бодлыг нь сонсож, уул уурхайн томоохон аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаад ирсэн. Үүнтэй холбогдуулан Гурвантэс суманд Гал түймэр унтраах, аврах анги байгуулах, сумын төвийн эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр цахилгаан станц барих ажлыг ирэх оноос эхлүүлэх, сумын Эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн зориулалтын автомашин хуваарилж олгохыг холбогдох сайд нарт даалгалаа. Мөн ”Нарийнсухайт-Шивээхүрэн” чиглэлийн 45.3 км төмөр замын ажлыг “Монголын Алт” компани болон нүүрс экспортлогч аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх ажлыг эхлүүлэх, улсын тусгай хамгаалалттай Тост, Тосонбумбын нурууны нутгийн хилийн заагийг тогтоохыг салбарын сайд нарт даалгав.

## 70 сая хүртэлх еврогийн зээлийн гэрээ байгуулахыг зөвшөөрөв

Олон улсын хөрөнгө оруулалтын банктай 70 сая хүртэлх еврогийн зээлийн гэрээ байгуулахыг Сангийн сайдад зөвшөөрөв. Долоо хүртэлх жилийн хугацаатай, 3.89 хувийн хүүтэй энэ зээлийг өрийн үйлчилгээний зардлыг бууруулах, зээлийн эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасгахад зарцуулахаар Засгийн газраас төлөвлөж байгаа аж. Эрчим хүч, зам тээврийн салбарт 2017 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг баталлаа. Эрчим хүч, зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг баталлаа. Жагсаалтад багтсан төслийг түлхүүр гардуулах нөхцөлөөр хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх нөхцөлтэйгөөр гүйцэтгэгчийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шалгаруулах юм. Төсөл, хөтөлбөрүүдийг 2017 оны эхний улиралд багтаан гэрээ байгуулж, ажлыг нь эхлүүлэхийг холбогдох сайд нарт даалгалаа. Уг жагсаалтад Дулааны III цахилгаан станцын хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөх төсөл, Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлэх, дулаан дамжуулан сүлжээг өргөтгөх төсөл, Багануур-Чойрын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, Багануурын дэд станцыг өргөтгөх төсөл багтжээ. Мөн Чойрын дэд станц барих, өргөтгөх төсөл, Хөшөөтийн уурхайгаас Ховд аймгийн Алтай сум хүртэлх 35 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл, Чойбалсан хотоос Хөөтийн уурхай хүртэлх 192 км төмөр зам барих төсөл, Хөөтийн уурхайгаас улсын хилийн Бичигт боомт хүртэлх 234 км төмөр зам барих төсөл, Зүүнбаян өртөөнөөс улсын хилийн Ханги боомт хүртэлх 281 км төмөр зам барих төсөл, Нарийнсухайтын уурхайгаас улсын хилийн Шивээхүрэн боомт хүртэлх 45.3 км төмөр зам барих төслүүд багтсан байна.

# Г.САМПИЛ: НҮҮДЛИЙН МАЛ АЖ АХУЙГАА УСТГАВАЛ



Н.БАТЗАЯА

*Монгол Улсын гавьяат малчин, хөдөө аж ахуйн ухааны профессор Г.Сампилыг энэ удаагийн “Чухал хүн” буландаа урьж, ярилцлаа.*

**-Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын малчин хүн хэзээнээс эхэлж, шинжлэх ухааны судалгааны ажил хийх болов гэдэг сонин байна. Энэ тухайгаас ярилцлагаа эхлэх үү?**

-Би 1950 онд Хэнтий аймгийн Жаргалтхаан суманд бага сургуулиа төгсөөд 20 нас хүртлээ аав, ээжийн хамт мал маллаж ирсэн. Би ч малын тоосонд өссөн хүн дээ. Гэхдээ социализмын он жилүүдэд арай өөр алба хашсан юм. Харин социализмын дараа ардчилсан хувьсгал гарч, малыг малчинд нь, өмчийг эзэнд нь гэдэг уриа дуудлагын дагуу аав, ээжийнхээ үлдээсэн их буян малтай золгосон доо. Түүнээс хойш мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлээд явж байна. Одоо би 80 нас хүрч байгаа хүн шүү дээ. Үүнийг хэлдгийн учир гэвэл мал маллах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн ажиллагаанд идэвхтэй оролцвол хүн эрүүл байхаас гадна урт наслаж, баялгийг бүтээдэг юм байна.

**-Мал маллахын хажуугаар шинжлэх ухааны судалгааны ажил, бүтээл туурвисан гэсэн. Судалгааныхаа ажлын талаар ярихгүй юу?**

-Энэ шинжлэх ухаан гэхээсээ илүү уламжлалт, бэлчээрийн мал аж ахуйн технологи юм. Өлчир омгийн мал сүрэгтэй байна гэдэг нь. Бид социализмын он жилүүдэд малын дулаан хашаа, саравч бэлтгэх, материал техникийн бааз байгуулна гэж явж байгаад өнө эртний уламжлалыг алдчихсан. Өөрөөр хэлбэл, монголчуудын өн эртний уламжлалт технологийн дагуу шалгарлаар бий болсон мал сүргийн байгальд тэсвэртэй, төлөрхөг, ашиг шим өндөртэй чадваруудыг алдчихсан юм. Ер нь хувьчлалын үеэр бээрэг, хэнз доройн, давжаа мал сүрэг л малчдын гар дээр очсон. Тэгэхээр бидэнд уламжлалт бэлчээрийн мал аж ахуйгаа эрхлэхийн тулд уламжлалт технологио сэргээж, үр дүнг нь хүртэх шаардлага зайлшгүй байсан. Зах зээлийн онол ч гэсэн тийм. Хамгийн хямд зардлаар үр ашигтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь зах зээлийн эдийн засгийн онол. Тухайн үед миний өмнө мал аж ахуйгаа нөгөө л социализмын аргаараа хашаа хороо, өвс тэжээл бэлтгээд, байшин барилга барих уу эсвэл уламжлалт технологи руу оруулаад хямд зардлаар мал сүргийнхээ тоо болон бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх үү гэдэг асуудал тулгарсан. Би уламжлалт тал руугаа илүү анхаарсан. Ээж, аав минь ч тийм байсан. Манайх анх 1956 онд Хэнтий аймгийн Баянмөнх сумын Мөнх-Оргил нэгдэлд 7000 тоо толгой мал сүргээ нийгэмчилж байлаа. Гэхдээ тухайн үед 7000 малыг хашиж тэжээгээд өндөр ашиг шим, өргөн үйлдвэрлэлд хүргэж байсан гэж бодохын аргагүй. Тиймээс нэгдүгээрт, аав ээж буурал дээдсийнхээ мал маллах арга ухааныг эзэмших хэрэгтэй байсан. Хоёрдугаарт, уламжлалт технологийг дэлгэрүүлэх шаардлагатай байсан. Тэр дундаа мал сүргийг өлчиржүүлэх, өлчир омог хэвшлийн мал сүрэг бий болгох хэрэгтэй болсон. Тэгээд тэр үйл ажиллагаа явагдсаар байгаад 2013 оны үед би өлчир омог хэвшлийн 4000 гаруй мал сүргийг бий болгосныг тогтоосон. Түүнийг зүгээр нэг үзэмжээр тогтоочихгүй шүү дээ. Генетикийн лаборатори өлчир омог хэвшлийн малын мах, сүү байна гэдгийг тогтоодог. Шинжлэх ухаан талаас нь судалж, тогтоосон. Өөрөөр хэлбэл, задгай өлчиржүүлэх замаар малласан малыг хашиж маллададаг малтай харьцуулахад өөхний царцанги, хайлмаг чанар илүү өндөр үр ашигтай байсан. Тэгж өлчир омог хэвшлийн мах бий болсныг лабораторийн шинжилгээгээр тогтоогоод түүнийг үндэслэн надад Хөдөө аж ахуйн профессор хэмээх алдар цолыг хайрласан. Энэ бол мэргэжлийн шинжлэх ухааных нь хувьд шүү дээ.

**-Өлчир омог гэхээр ямар омог байна вэ. Ер нь өлчир омгийн малыг өсгөж, үржүүлэх нь ямар ач холбогдолтой юм бэ?**

-Хамгийн энгийнээр тайлбарлахад даардаггүй мал юм даа. Өөрөөр хэлбэл, ялангуяа манай орон шиг эрс тэс, хүйтэн сэрүүний улирал зонхилдог улсад амьдрахад тун тохиромжтой. Хашаа, тэжээл шаардахгүйгээр амьдрах байгаль биологийн зохицолдолгоог бүрдүүлсэн мал сүргийг өлчир омог гэж байгаа юм. Өлчир омог хэвшлийн мал хариулж байгаа эзэндээ маш их үр өгөөжтэй. Нэгдүгээрт, байгалийн аюулт үзэгдэл зуд турханыг даах чадвартай. Нэг үгээр хэлбэл амьдрах чадвар сайн гэсэн үг. Хоёрдугаарт, өндөр ашиг шимтэй. Ноос, ноолуур гээд малаас гардаг ашиг шимийн бүтээгдэхүүн нь илүү байдаг. Гуравдугаарт, төлөрхөг чанар сайтай. Дөрөвдүгээрт, өвчин эмгэг тусах нь бага. Ер нь хүн дээр жишээ аваад бодоход тив, дэлхийн олон улсын тэмцээнд оролцож байгаа тамирчдын ихэнх нь борог энгийн амьдралд өсч, бие бялдар нь хөгжиж тодорхой шалгарлаар хүчтэй нь гарч ирдэг. Мал сүрэг үүнтэй яг адилхан. Ийм маягаар өлчир омог хэвшил бий болдог. Өлчир омгийн малын ашигтай тал гэвэл илүү их бүтээгдэхүүн гардаг, амьдрах чадвар илүү өндөр, өвчин эмгэг тусч үрэгдэх нь бага, бие бялдар нь өсгөлүүн.

**-Та өлчир омгийн малыг 4000 толгой болтол өсгөж, эрдмийн цол зэрэг хүртэл хүртсэн байна. Энэ хүртэл хэдий хэр хугацаа зарцуулав?**

-Энэ 20 гаруй жилийн хөдөлмөр л дөө. 1993 оноос эхэлсэн. Хангалттай хугацаа. Шинжлэх ухааны талаас нь бодоод үзсэн ч тэр. Нобелийн шагналыг 10 жилийн тодорхой үр дүнгээр л өгч байна шүү дээ.

**-Өлчир омог маш их ашигтай юм байна. Гэтэл хүн бүхэн өлчир омгийн малыг өсгөдөггүй. Ер нь өлчир омгийн малд маллахад төвөгтэй гэдэг ч юм уу, сул талууд байна уу?**

-Сул тал гээд байх юм нэг их байхгүй. Яах вэ, нэг сул тал нь нэлээд эмнэг догшин, эрэмгий. Тухайлбал, гарын маллагаанд орж ирэхдээ бархшээлтэй. Яагаад гэвэл задгай нөхцөлд байдаг учраас гар ажиллагаанд ороход хэцүү л дээ. Ер нь зэрлэг ан амьтдыг гэрийн тэжээмэл амьтан болгодог шүү дээ. Сул тал гэвэл тийм л байна. Өөр сул тал олж хараагүй.

**-Танай аймагт өлчир омгийн мал маллаж байгаа хүмүүс бий юу. Магадгүй таниас энэ омгийн малыг өсгөх арга ухааныг уламжилж авсан хүмүүс байгаа байх?**

-Их олон бий. Зүүн гурван аймагт байна. Тэр дундаа миний гарын шавь Сүхбаатар аймгийн Халзан сумын Мөнхтөр гээд том хот айлын аж ахуй эрхэлдэг хүн бий. Хэнтий аймаг 800 гаруй мянгат малчинтай. Түүний ихэнх нь өлчир омгийн мал маллаж байгаа хүмүүс байдаг. Яг таны шавь гэдэггүй ч гэлээ намайг хараад дуурайгаад явж байгаа хүмүүс Хэнтий аймагт олон. Ялангуяа тал хээрийн бүс нутаг буюу Дорнод, Сүхбаатар аймгийн нэлээд сумдад бий. Дорнод аймгийн Баяндунгийн Батмөнх гэж 10 мянган малтай. Мөн л уламжлалт аргаар малаа өсгөж, 10 мянгад хүргэсэн хүн хүртэл байна. Гэхдээ малчид нэг их гарын шавь гэж яриад байдаггүй. Энэ бол нэлээд хуучин ойлголт, сэтгэлгээ. Миний энэ аргыг сум болон ойр орчмын хүмүүс жилийн дөрвөн улиралд малаа хашихгүйгээр малладаг. Манай аймгийн баруун хойд талын сумын малчид малаа байнга хашдаг байсан бол одоо задгайлаад эхэлж байна. Үр дүнг нь олоод харчихаж байгаа юм. Угаасаа тэр арга ухаан бол ганцхан миний бүтээл биш. 800 жилийн тэртээгээс Монголын уламжлалт технологи, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлсэн өвөг дээдсийн маань мал маллах ухаан байхгүй юу.

**-Социализмын үед их, бага хэмжээгээр энэ арга ухаан алдагдаж, тийм үү?**

-Их, бага биш бүхэлдээ алдагдсан. Технологийг бүхэлд нь алдагдуулсан. Социализм Монголд 40 жил амьдарсан. Гэтэл бэлчээрийн уламжлалт мал аж ахуйг монголчууд 800 жил эрхэлж ирсэн. Яаж ч бодсон олон мянган жилийн ажлын үр дүн илүү байна биз дээ. Тиймээс би түүнд суурилж, өлчир омгийг үржүүлэх ажил явуулсан.

**-Сүүлийн үед малын бэлчээрийн даацын асуудал их хөндөгдөж байна. Хэт олон мал бэлчээрийн даацгүй болгоно гэсэн хэсэг хүмүүс байхад уламжилж ирсэн мал аж ахуйгаа л өсгөх хэрэгтэй гэх хүмүүс ч байдаг. Та энэ тал дээр ямар бодолтой байдаг вэ?**

-Малын тоо толгой олон болсноос бэлчээр доройтож байна гэдэг зүйл ярьдаг хүмүүс бий. Энэ бол буруу хазгай дүгнэлт. Малыг үзэн ядах сэтгэлгээнээс гарч ирсэн үг, яриа яваад байна л даа. Монголын бэлчээр нутаг дээр 80-90 мянган мал бэлчээрлээд байх боломжтой. Манай улсад 126 сая бэлчээр нутаг байна. Олон мал бэлчээр доройтуулаад байгаа юм биш. Харин мал маллах арга ажиллагаанд уламжлалт технологи жаахан алдагдсан явдал бий. Үүнээс шалтгаалаад нүүдэл суудал бага хийдэг, жилийн дөрвөн улиралд нэг нутагтаа суурьшдаг асуудал гарч ирсэн. Энэ бол мал маллах арга ухааны технологи алдагдсаных юм. Нөгөөтэйгүүр бэлчээрийг доройтуулахад хамгийн ноцтойгоор нөлөөлж байгаа зүйл нь уул уурхай, дэд бүтцийн асуудлууд байна. Зам барилгын ажил, уул уурхайн олборлолтыг бэлчээрт ямар хор хөнөөл учруулж байгааг харахгүйгээр хийдэг. Уг нь байгальд хохирол учруулахгүйгээр хийх ёстой юм. Тэр бүү хэл хүний хөл хүрээгүй сайхан зүлгэн дээр давхиж байгаа машинууд бэлчээрт үй түмэн хохирол учруулж байна. Энэ бүхнийг бид цэгцэлж, олж харж, яриагүй хэрнээ малчдын эдийн засгийн гол хөшүүрэг болсон хэдэн мал нь өсөөд ирэхээр бэлчээрээр шалтаглаад байдаг. Ийм мал аж ахуй, мал сүргээ үзэн ядсан зүйл байж болохгүй. Үүнд гадаадынхны ч үг явж байж магадгүй. Яагаад гэвэл цөөхөн малтай болчихвол энэ их өргөн уудам газар нутаг эзгүй зэлүүд болно шүү дээ. Тэгвэл тэр зэлүүд нутаг дээр хэн амьдрах юм. Тэр өдөр, шөнөгүй Монголын баялагт санаархаж, савраа шургуулах гэж өнгөлздөг гадаадын компаниуд шуугиад л ороод ирнэ. Манай нөхдүүд ч найр тавиад өгчихнө. Тэгэхээр магадгүй бэлчээр эзэмшүүлэх хууль гаргана, цөөхөн малтай болбол сайхан болно гэдгийн ихэнх нь гаднынхны бодлого ч явж байж мэдэх талтай. Нөгөө талаасаа нүүдэлчдийн соёл иргэншлийг устгаж, монголчуудыг мөхөөх гэсэн үйл ажиллагаа юм. Оросын агуу их судлаач Лэв Гүнлэв “Монголчуудыг нүүдэлчин амьдралаас нь салгачихвал тэгээд л мөхчих улс. Тэдэнд дайн тулалдаан, буу зэвсэг хэрэггүй” гэж хэлж байсан. Мөн манай улсад суурьшлын соёл, иргэншил их болж байна л даа. Нам төрийн удирдлагууд ч хэлж байна. 2025 он гэхэд бүх хүн амын 70 гаруй хувийг орон сууцанд оруулна гээд л ярьцгааж байна. Ерөөсөө л Улаанбаатараа хүртэл “Аз жаргалтай хот” гэж нэрлэж байгаад жаргалын оронд очиж амьдаръя гэдэг сэтгэлгээг хүмүүст өгч байна. Тэгэхээр хөдөө малаа маллаж байгаа малчин зовлонгийн далайд живж буй амьтан болох гээд байгаа биз. Мэдээж жаргал гэдэг үгний эсрэг нь зовлон. Ийм улс төрийн алдаатай уриа лоозон гаргаж, ард иргэдээ төөрүүлэх нь буруу. Тиймээс мал аж ахуйгаа уламжлалт технологиор авч явахын тулд энд тохирсон бодлого байх хэрэгтэй. Яах вэ тодорхой газруудад байшин, барилга хэрэгтэй. Гэхдээ яг тэр бодлоготойгоо эн тэнцүү уламжлалт бэлчээрийн мал аж ахуй, нүүдэлчин амьдралыг хадгалж үлдэх ёстой. Монголчууд хүн төрөлхтний хамгийн сүүлийн нүүдэлчин улс. Хэрвээ энэ нүүдэлчин соёл иргэншил уствал дэлхийн хүн төрөлхтний нүүдэлчин соёл устана гэсэн үг. Дэлхий дээр нүүдэлчин соёл байсан, хамгийн сүүлийн улс нь

## ЧУХАЛ ХҮН



# МОНГОЛЧУУД СҮЙРНЭ

...Малчдад хот айлаар нь сургалт явуулж болно. Өрхийн сургалт, өрх гэрийн засаглал гэж том зүйл байсан. Тэр алдагдсан. Монгол төрийн гол үндэс нь өрхийн засаглал юм. Гэтэл өнөөдөр Монгол төрийн үндсэн нэгж нь баг гэж буруу тодорхойлчихсон. Энэ бол буруу заалт...

Монгол байсан л гэж ярих болно. Монголын нүүдэлчин амьдралыг өөрчлөх гэж байгаа бол дэлхийн өмнө уучилж баршгүй том нүгэл хийх гэж байна гэдгийг Монгол Улсыг удирдаж байгаа нөхдүүд ойлгох хэрэгтэй. Харин үүнийг бид хэлэх ёстой. Би энэ дарга нартай адилхан элдэв уриа, улс төрийн зорилгоор Шинэ Зеландын мал аж ахуй нь тийм байдаг гэж ярьж байгаа хүн биш шүү дээ. Би үе дамжсан удмын малчин. 5000 өлчир омгийн мал сүрэг бий болгосон хүн. Энэ асуудлаараа ч шинжлэх ухааны цол хэргэм авч, дүгнэлт гаргуулсан. Намайг дагасан мянга мянган малчид манай улсад байна. Надтай байнга харьцаж, утсаар болон өөрийн биеэр зөвлөгөө авч байгаа хүмүүс бий.

**-Манай улсад фермерийн аж ахуй хөгжиж байгаа. Үүнтэй холбогдуулан малыг чиглэл чиглэлээр нь өсгөж байна. Тухайлбал, мах, сүүний гэх мэтчилэн малыг ангилан өсгөх болсон. Таны бодлоор фермерийн аж ахуйг хөгжүүлэх нь хэр зөв бэ?**

-Монголын мал аж ахуйн 20 хувийг фермерийн аж ахуй эзэлдэг. Фермерийн аж ахуй өөрөө амьдрах орчин, цаг хугацаа заадаг. Тухайлбал, суурин, хагас суурин газар эсвэл газар тариалан илүү хөгжсөн, хүн ам шигүү суурьшсан, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулах зах зээл нь ойрхон газруудад л хөгждөг. Түүнээс 200 гаруй мянган өрхийг фермерийн аж ахуйд эрхлүүлээд амьдралыг нь сайхан болгоно гэвэл түүн шиг үлгэр байхгүй. Фермерийн аж ахуйн өндөр ашиг шимтэй мал амьдрах дулаан байр, их хэмжээний тэжээл, зориулалтын тарилга тарьдаг. Ингэж байж ашиг шимээ өгдөг. Дэлхийн олон улсууд фермерийн эрчимжсэн аж ахуйгаасаа татгалзаж байна. Англи улсад гэхэд үхрийн галзуу өвчин гарсан. Түүнээс болж хэдэн мянган үхэр фермертэйгээ устгуулж байна шүү дээ. Гэтэл Монголд үхрийн өвчин Төв аймагт гарлаа гэхэд тэр аймгийн хот айлд болоод, голомтод нь өвчнийг нь устгадаг. Бусад аймгуудаар тарсан 300 мянган өрхөд хүртээлгүй асуудал. Тиймээс энэ хоёрын эерэг, сөрөг талыг ойлгоё гэвэл энэ жишээ л байна. Фермерийн аж ахуй гэдэг газар тариалан их хөгжсөн, хадлан бордоо, тэжээлийн нөхцөл сайжирсан орчинд л хөгжинө. Жишээлбэл, Сэлэнгэ аймгийн Төв район, Улаанбаатар, Эрдэнэтийг тойрсон газруудад хөгжих боломжтой. Монголын бүх малчдыг фермерийн аж ахуйд шилжүүлнэ гэвэл түүн шиг тэнэг зүйл байхгүй. Тийм хүн байвал эх орноосоо урвасан, үндэснийхээ эрх ашгийг хохироосон, үндэсний үзэл баримтлалын талаар огт ойлголтгүй хүн. Тийм л хүмүүсийн амнаас унадаг үг. Монгол хүний амнаас ийм үг унахгүй.

**-Манай залуучууд мал маллахаа больж, хот газрыг бараадах болсон. Түүнээс болж хөдөө, орон нутаг хүнгүй болж байна. Энэ юунаас болоод байна вэ. Залуучууд яагаад хот газар руу шуураад байна вэ?**

-Манай улсын тогтолцоо л буруу байхгүй юу. Жишээлбэл, боловсролын систем гэхэд хүүхдийг зургаан настайд нь сургуульд суулгаж байна. Зургаан настай эхийнхээ өврөөс гараагүй хүүхдийг л хуулиараа сургуульд сургачихаж байна. Тодорхой жишээ дурьдвал сургуульд орох насны хүүхэдтэй малчин өрх байлаа гэж бодъё. Хүүхэд нь сумын төв рүү сургуульд явахаар ээж нь дагаад явна. Аав нь малаа маллаад үлдэнэ. Ингээд хоёр нэг гэр бүлийн хоёр тусдаа амьдраад байж болохгүй шүү дээ. Түүнээс болж их удлаа гэхэд 2-3 жил болоод л "За болъё. Малаа зарья. Хот газар бараадъя" гэдэг шийдвэрийг гаргадаг. Бодлогын том алдаа, системийн буруугаас болоод л ард иргэдээ хот газар руу татаад байна. Түүнээс залуучууд мал маллах дургүйдээ хот руу яваад байгаа юм биш шүү дээ. Манай төр засгийн бодлогын нэг алдаа нь үргэлж төв, хот суурин газар руу иргэдээ татах юм ярьдаг. Жаргалын найман хотод хүрээд ир. Тэнд сайхан байшин барина, диваажингийн орон гэх нь холгүй хүмүүсээ сэнхрүүлээд байдаг. Ямар сайндаа л "Жаргалтай Улаанбаатар" гэх вэ дээ. Энэ бол ёстой оновчгүй нэр. Гэтэл малчид гэдэг чинь том баялгийн үйлдвэрлэл, баялаг бүтээгчид юм. Тэр баялаг бүтээгчдийг үйлдвэрлэлийнх гол бүтээгдэхүүн болсон мал, бэлчээр газраас нь холдуулахгүйгээр хөгжүүлэх бодлого баримтлах хэрэгтэй. Тухайлбал, малчдад хот айлаар нь сургалт явуулж болно. Өрхийн сургалт, өрх гэрийн засаглал гэж том зүйл байсан. Тэр алдагдсан. Монгол төрийн гол үндэс нь өрхийн засаглал юм. Гэтэл өнөөдөр Монгол төрийн үндсэн нэгж нь баг гэж буруу тодорхойлчихсон. Энэ бол буруу заалт. Харин Монголын төрийн үндсэн нэгж нь баг биш өрх. Өрх дотор бүх ажил явагдана. Тийм учраас өрхийн тэргүүнийг хүндэлдэг, дээдэлдэг, өрхийн тэргүүн ч үр хүүхэддээ сургамжилж, амьдралаа авч явдаг. Өрхийн тэргүүн байгаа болохоор өрх дотор үйлдвэрлэл явагддаг. Нэхийгээ элдээд дээл хувцсаа хийчихнэ. Малынхаа бүх төрлийн бүтээгдэхүүнээр хоол, хүнсээ базаачихна. Ингээд ирэхээр хэнээс ч хамааралгүй амьдардаг. Энэ амьдрах ухааныг алдсанаас болж монголчууд яаж хохирч байна. Хамгийн ойрын жишээ хэлэхэд, Далай лам манай улсад айлчилсны төлөө Хятад улс хилээ хаана, хэлэлцээрээ таслана гэж сүрдүүллээ. Монголчууд буддын шашинг шүтэх эрхээ Хятадаар заалгаж, шийдүүлэх гэж байна. Хэдийгээр Үндсэн хуульд шашин шүтэх эрхтэй гэж заасан боловч Далай ламыг эх орондоо урих ч эрхгүй л байгаа хэрэг. Нэг үгээр, бидний эрхийг хааж, боогдуулж байна. Ард түмний эрхэнд бүдүүлгээр халдсан. Үүнийг олон улсын шүүх, хүний эрхийн хороонд ч өгмөөр асуудал болсон. Дэлхийн хаана ч хөрш орныхоо иргэдийн шашин шүтэх эрхэнд халдсан явдал байхгүй. Яагаад бид Хятадаас зөвшөөрөл авч байж бурхан шашиндаа мөргөх ёстой гэж. Тийм зүйл байж болохгүй.

**-Хан Хэнтийн мянгат малчны холбооныхоо талаар сонирхуулаач. Одоогоор хэдэн гишүүнтэй байна вэ. Ямар үйл ажиллагаа зохион байгуулав?**

-Би 1998 онд Хан Хэнтийн мянгат малчны холбооны тэргүүн болсон. Тэр үед Хэнтий аймаг 37 мянгат байсан. Одоо 890 гаруй мянгат малчинтай болсон. Мянгат малчны тоог 10 дахин өсгөсөн.

**-Ер нь танай аймгийн мянгат малчдад ямар бэрхшээл тулгарч байна вэ?**

-Олон зүйл бий. Төр засгийн алдаатай бодлогоос эхлээд л боловсрол, Бэлчээр эзэмшүүлэх тухай хуулийн төсөл оруулж, хоршоог дэлгэрүүлэх гэх мэтчилэн олон асуудал гарч ирдэг. Тэр болгонд л төрийн бус байгууллага тэмцдэг. Тэмцэх ч ёстой. Учир нь төрийн бус байгууллага гишүүдийнхээ эрх ашгийн төлөө л ажиллана. Түүнээс биш Засгийн газар, орон нутгийн засаг захиргаатай хамтарч малчдаа дарамталж явдаг байгууллага биш. Малчдын эрх ашгийн төлөө зогсдог, тэмцдэг. Ер нь манай Хан Хэнтийн мянгат малчны холбоо бол хамгийн идэвхтэй ажилладаг төрийн бус байгууллага. Жишээлбэл, Бэлчээр эзэмшүүлэх тухай хуулийн төслийг дөрвөн удаа УИХ-аар батлуулах гэж үзсэн. Тэр болгонд манай холбооны эсэргүүцэлтэй тулгараад хойшлогддог. Манай холбооны үйл ажиллагаа хүчтэй. Хэнтий аймгийн Хэрлэнгийн Хөдөө арал гэх түүхэн нутагт Хятадын компани нүүрсний уурхай гаргах гэж байсан. Бид холбооныхоо шугамаар асар том хөдөлгөөн өрнүүлж, цөөхөн хоногийн дотор Хятадын компанийг хөөж гаргасан. Төрийн бус байгууллага бол ингэж л ажиллах ёстой. Нэг компанид тал зассан, дарга нарт зулгуйдсан ажил хийвэл төрийн бус байгууллага гэх нэр зүүх хэрэг ч байхгүй. Энэ мэтчилэн олон ажил бий. Бид малчдыг ажил хөдөлмөрийг мэргэжлийн хөдөлмөр болгож, үнэмлэх дипломатай болголоо. Малчин өрхийг хуулийн этгээд болгон данс, тамгатай болгосон.

### Аймгаас мэдээлж байна

ДОРНОГОВЬ АЙМАГ

## БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газартай хамтран ажиллана

2016-2020 оны аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөрш болон өндөр хөгжилтэй орнууд, тэдгээрийн муж, хотуудтай шууд харилцаа тогтоож, хамтын ажиллагааг хөгжүүлэн, олон тулгуурт гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газар хамтран ажиллаж байна. БНХАУ-аас Замын үүд суманд суугаа Ерөнхий консул Цай Вень Руй тэргүүтэй төлөөлөгчид энэ сарын 2, 3-ны өдрүүдэд Дорноговь аймагт ажиллах бөгөөд аймгийн удирдлагууд болон эрүүл мэнд, боловсролын салбарын төлөөллүүд өнөөдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр хоёр тал хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж, цаашид хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх ажлууд болоод хоёр улсыг ижил төвшинд хөгжүүлэх тухай харилцан санал солилцлоо. Мөн БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газраас Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газарт зөөврийн компьютер, хувилагч, принтер зэрэг албан хэрэгцээний тоног төхөөрөмжийг бэлэглэлээ.

СЭЛЭНГЭ АЙМАГ

## Багш нарын урлагийн их наадам боллоо




"Багш нарын урлагийн анхдугаар их наадам-2016" арга хэмжээг Сэлэнгэ аймгийн "Залуу багш нарын холбоо"-ноос санаачлан Сэлэнгэ аймгийн Засаг даргын ивээл дор анх удаа зохион байгуулжээ. Залуу багш нарын санаачлан хэрэгжүүлж буй уг арга хэмжээг аймгийн Засаг дарга дэмжиж, ивээл дороо зохион явуулсан нь онцлогтой ажээ. Тус наадмын нэгдүгээр шатны шалгаруулалтыг аймгийн хэмжээний таван бүсийн хүрээнд явуулсан бөгөөд сүүлийн шалгаруулалтыг аймгийнхаа төвд зохион байгуулсан байна. Энэ удаагийн багш нарын урлагийн анхдугаар их наадам нь чөлөөт үзүүлбэр, гоцлол дуу, гоцлол бүжиг, хамтлаг дуу, хамтлаг бүжиг, үндэсний хөгжим гэсэн төрлүүдээр явагдаж, авьяастнуудаа тодруулсан аж. Анхдугаар их наадмын тэргүүн байрт "Бэлчир"-ийн бүс, дэд байрт "Хараа" бүс, гуравдугаар байрт "Орхон" бүсийн багш нар шалгарч, их наадмын анхны шагналын эзэд болжээ.

БУЛГАН АЙМАГ

## Ойжуулагчийн ангийн дадлагын талбайд ажиллав

Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй 2014 оноос хамтран ажиллаж байна. Төслийн зүгээс Хөдөө аж ахуйн МСҮТ-ийн "Ойжуулагч" мэргэжлийн ангийн дадлага хийх техник, төхөөрөмж, багаж хэрэгсэл, хичээл үйлдвэрлэлийн зардал зэрэг 242 сая төгрөгийн бодит хөрөнгө оруулалтыг хийжээ. Энэ хугацаанд багш нарыг мэргэжил дээшлүүлэх, чадваржуулах, гадаад дотоодод туршлага судлуулах олон сургалт, семинар, аялалд хөрөнгө оруулалт хийсэн байна. ГОУХАН-ийн "Уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь-2" төслийн хүрээнд хэрэгжиж буй "Ойжуулагч" мэргэжлийн дадлагын ой болох Бугат сумын "Ерхөг" ХХК-ийн эзэмшил ойн санд Аймгийн Засаг даргын орлогч Ц.Бат-Өлзий, Булган сумын сум дундын ойн ангийн дарга Б.Алтансүх, Хангайн бүсийн арга зүйн төвийн менежер Ё.Бадамхатанд нар багш сурагчдын дадлагын ажилтай танилцжээ. Түүнчлэн уг төсөл хөтөлбөрийн Захирал Клаус Шмидт-Корситто, мэргэжилтэн Д.Чулуунцэцэг, GIZ дадлагажигч Фредерик Шмидт нартай багш, суралцагчдын дадлагын ажилтай танилцаж хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийн мониторингийг хийсэн байна. Энэхүү хөтөлбөрийн дүнд ойн зохистой, тогтвортой, зөв менежментийг хэрэгжүүлэх ойн мэргэжлийн байгууллагыг чадавхижуулах болон түүнд ажиллах мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх гол зорилготой юм.

ОРХОН АЙМАГ

## Энэ онд 1500 айлд сайжруулсан зуух олгоно

Хотын агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллын айлуудыг түлш бага зарцуулах боломжоор хангаж улмаар өрхийн эдийн засагт бодит хэмнэлт бий болгох зорилгоор сайжруулсан зуух олгох ажлыг эхлүүлээд байна. Зуух нэг бүрийн өртгийн 70 хувийг төрөөс санхүүжүүлж иргэдэд хөнгөлөлттэй үнээр олгох юм. Уг ажилтай аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинжаргал танилцлаа. Энэ онд манай аймгийн 1500 өрхөд сайжруулсан зуух олгоход нийтдээ 500 сая төгрөг зарцуулж байна. Үүний 200 сая төгрөгийг Байгаль хамгаалах зардлаас, 300 сая төгрөгийг БОНХАЖЯ-аас төсөвлөсөн гэж Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн ярьлаа. Сайжруулсан зуухыг гэр хорооллын багуудыг бүсчлэн олгож байсан. Энэ удаа Рашаант, Уртын гол багийг сонгосон боловч борлуулалт хангалтгүй байжээ. Тиймээс нэмж Шанд, Даваат, Яргуйт, Их залуу багт олгохоор болсон байна. Уг ажил нь хавар эхэлсэн бөгөөд эхний олголтоор 600 орчим айлыг хөнгөлөлттэй үнээр сайжруулсан зуухтай болгосон. Одоо 800 гаруй айлыг нэмж хамруулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын газар ажиллаж байна. Аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинжаргал тус газрын мэргэжилтнүүдэд сайжруулсан зуухыг нэг айлд давхардуулж олгохгүй байх чиглэл өглөө.

# МЭДЭЭЛЭЛ

## ЭРХЭМ ЗАХИАЛАГЧ ТА “МОНГОЛ ШУУДАН” КОМПАНИД ХЭВЛЭЛЭЭ ЗАХИАЛНА УУ!

## 2017 ОНЫ I УЛИРЛЫН ХЭВЛЭЛ ЗАХИАЛГА СУМДАД 12-Р САРЫН 25-ИЙГ ХҮРТЭЛ, УЛААНБААТАР ХОТ БОЛОН АЙМГИЙН ТӨВҮҮДЭД 12-Р САРЫН 29-ИЙГ ХҮРТЭЛ ЯВАГДАНА

Хэвлэл захиалгын мөнгийг Улаанбаатар хотод “Монгол шуудан” Төрийн банкны 100000139702 тоот дансанд, бусад аймаг, хот, сум, суурин газруудад тус тусын банкны салбар дахь тухайн аймгийн шуудангийн газрын хэвлэлийн харилцах дансанд тушааж холбогдох тооцоог хийнэ.

**“МОНГОЛ ШУУДАН” ХК**
**УТАС/ФАКС: 70078916, 70078977,**
**ШУУДАН ЛАВЛАХ: 1800-1613**

ДАРААХЬ ХЭВЛЭЛҮҮД РЕДАКЦИАС ГАРААГҮЙ ТУЛ БУЦААН ТООЦОО ХИЙНЭ ҮҮ!

| Д/д | ИНДЕКС | ХЭВЛЭЛИЙН НЭР | УЛИРАЛ |
|---|---|---|---|
| 1 | 200114 | ДЭЭД ШҮҮХИЙН МЭДЭЭЛЭЛ | 1,2,3-Р УЛИРАЛ |
| 2 | 202091 | БИ ӨӨРӨӨ /4-6 НАС/ | 3-Р УЛИРАЛ |
| 3 | 200209 | БИ ӨӨРӨӨ /2-3 НАС/ | 3-Р УЛИРАЛ |
| 4 | 201061 | БАГА АНГИЙН БАГШ | 3-Р УЛИРАЛ |
| 5 | 203004 | БАГШЛАХ УРЛАГ | 3-Р УЛИРАЛ |
| 6 | 203014 | ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ | 3-Р УЛИРАЛ |
| 7 | 228281 | ГРАНД | 3-Р УЛИРАЛ |
| 8 | 236047 | MONGOLIAN ECONOMY /сүүлийн 3 дугаар/ | 3-Р УЛИРАЛ |
| 9 | 295663 | MARKETING TODAY | 3-Р УЛИРАЛ |

### ӨДӨР ТУТМЫН СОНИН

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Хагас жил | | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 100757 | МОНГОЛЫН МЭДЭЭ | 128 | 44800 | 64 | 22400 | 44 | 19800 |
| 100943 | АРДЧИЛАЛ | 130 | 36000 | 64 | 18000 | 44 | 16000 |
| 102108 | ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ+Financial Times | 128 | 60000 | 64 | 30000 | 44 | 21000 |
| 100774 | ЗУУНЫ МЭДЭЭ | 130 | 35000 | 65 | 17500 | 43 | 12000 |
| 100004 | МОНГОЛЫН ҮНЭН | 128 | 30000 | 64 | 15000 | 42 | 10000 |
| 101545 | ӨГЛӨӨНИЙ СОНИН | 124 | 40000 | 64 | 20000 | 45 | 17000 |
| 100816 | ӨДРИЙН СОНИН | 128 | 39200 | 64-66 | 19600 | 44 | 13600 |
| 100518 | ӨНӨӨДӨР + /Ням гариг амралтын дугаар/ | 150 | 41800 | 75 | 20900 | 52 | 14500 |
| 105182 | ӨНӨӨДӨР + UB POST | 150+72 | 180700 | 75+36 | 88800 | 52+26 | 56200 |
| 114876 | УЛС ТӨРИЙН ТОЙМ | 122 | 36000 | 61 | 18000 | 45 | 15000 |
| 101361 | ҮНДЭСНИЙ МЭДЭЭ | 126 | 32000 | 61 | 16000 | 45 | 11000 |
| 101606 | ҮНДЭСНИЙ ШУУДАН /зууны шуудан/ | 128 | 40000 | 64 | 20000 | 44 | 14000 |

### ГУРАВ ХОНОГ ТУТМЫН СОНИН

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Хагас жил | | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 100673 | ШУУРХАЙ ЗАР /өдрийн шуудангаар хүргэгдэнэ/ | 48 | 72000 | 23 | 34500 | 17 | 25500 |
| 100501 | ЗАР МЭДЭЭ СУРТАЛЧИЛГАА /өдрийн шуудангаар хүргэгдэнэ/ | 49 | 73500 | 24 | 36000 | 17 | 25500 |
| 100537 | UB POST /Өнгөт, 12 нүүр, англи хэлээр/ | 72 | 140900 | 36 | 68900 | 26 | 43700 |

### 1. ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Хагас жил | | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 100335 | БИЗНЕС ТАЙМС | 24 | 24000 | 12 | 12000 | 8 | 8000 |
| 100029 | ГАН ЗАМ | 26 | 13800 | 13 | 6900 | 9 | 4800 |
| 101268 | МОНГОЛ ЦУШИН | 24 | 24000 | 13 | 12000 | 9 | 9000 |
| 100070 | MONGOL MESSENGER / МОНГОЛ ЭЛЧ/ | 26 | 24000 | 13 | 12000 | 9 | 9000 |
| 100702 | МОНГОЛЫН МЭДЭЭ / Хятад хэлээр/ | 26 | 24000 | 13 | 12000 | 9 | 9000 |
| 100184 | НОВОСТИ МОНГОЛИИ | 26 | 24000 | 13 | 12000 | 9 | 9000 |
| 101119 | OPEN DOOR /НЭЭЛТТЭЙ ХААЛГА/ | 24 | 26000 | 12 | 13000 | 8 | 9000 |
| 100018 | СОЁМБО | 26 | 10000 | 13 | 5000 | 9 | 3000 |
| 100459 | СЭРҮҮЛЭГ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 5000 |
| 101688 | УЛААНБААТАРЫН СОНИН | 24 | 22000 | 12 | 11000 | 8 | 7200 |
| 100011 | ХӨДӨЛМӨР | 24 | 13200 | 12 | 6600 | 8 | 4400 |
| 100178 | ХҮМҮҮН БИЧИГ | 24 | 6000 | 12 | 3000 | 8 | 2000 |

### 2. АРАВ ХОНОГ ТУТМЫН СОНИН

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Хагас жил | | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 100752 | БОЛСОН ЯВДАЛ | 18 | 27000 | 9 | 13500 | 6 | 9000 |
| 100161 | БӨХ | 18 | 14400 | 9 | 7200 | 6 | 4800 |
| 101175 | МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛ | 18 | 12000 | 9 | 6000 | 6 | 5000 |
| 100013 | МОНГОЛЫН ХӨДӨӨ | 12 | 12000 | 6 | 6000 | 4 | 4000 |
| 100645 | НОЦТОЙ МЭДЭЭ | 18 | 27000 | 9 | 13500 | 6 | 9000 |
| 101478 | ОДОО ЦАГ | 12 | 13200 | 6 | 6600 | 3 | 3300 |
| 100912 | САНХҮҮГИЙН МЭДЭЭ | 18 | 10800 | 9 | 5400 | 6 | 3600 |
| 103086 | УЛААН ОДХОН-ахмад дайчдын хэвлэл | 18 | 12000 | 9 | 6000 | 6 | 4000 |
| 100012 | УТГА ЗОХИОЛ, УРЛАГ | 18 | 10000 | 9 | 5000 | 6 | 4000 |
| 100474 | ҮГИЙН СҮЛЖЭЭ | 20 | 12000 | 10 | 6000 | 6 | 3600 |
| 159918 | ХОРИОТОЙ БҮС | 14 | 15400 | 7 | 7700 | 4 | 4400 |
| 100229 | ХӨХ ТОЛБО | 18 | 9000 | 9 | 4500 | 6 | 3000 |
| 101665 | ЭХ ОРНЫ МАНАА | 18 | 10000 | 9 | 5000 | 6 | 3500 |

### АРВАН ДӨРӨВ ХОНОГ ТУТМЫН СОНИН

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Хагас жил | | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 100164 | АМЬДРАХ УХААН | 12 | 9600 | 6 | 4800 | 4 | 3200 |
| 100624 | АНАГААХ АРГА БИЛИГ | 12 | 19200 | 6 | 9600 | 4 | 6400 |
| 100625 | АНАГААХ АРГА БИЛИГ /2015 ОНЫ ХУУЧИН ДУГААРУУД БАГЦ/ | | | 1 | 28800 | 1 | 28800 |
| 101560 | ДАЛД АМЬДРАЛ | 12 | 16000 | 6 | 8000 | 4 | 5400 |
| 100001 | МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧ | 12 | 10800 | 6 | 5400 | 4 | 3600 |
| 109110 | ОНЦГОЙ МЭДЭЭ | 12 | 9000 | 6 | 4500 | 4 | 3000 |
| 100064 | САНХҮҮ БАНКНЫ МЭДЭЭЛЭЛ | 12 | 12000 | 6 | 6000 | 4 | 4000 |
| 163451 | ЭРҮҮЛ МЭНДИЙН ЖОР | 10 | 15000 | 5 | 7500 | 3 | 4500 |
| 106105 | ДАЛД ЕРТӨНЦ СОНИН / ЗУРХАЙТАЙ ТУСГАЙ ДУГААР/ | ЖИЛД 1 ДУГААР 1500 | | | | | |

### 3. САР ТУТМЫН СОНИН

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Хагас жил | | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 101081 | БАГШ | 6 | 12000 | 3 | 6000 | 2 | 4000 |
| 101057 | ГЭР ГЭРТЭЭ ТОГООЧ | 6 | 10800 | 3 | 5400 | 2 | 3600 |
| 115457 | ГЕОЛОГИ УУЛ УУРХАЙН МЭДЭЭ | 6 | 6000 | 3 | 3000 | 2 | 2000 |
| 100520 | ДАЛ /Зөгнөлт сонин, Өнгөрсөн, одоо, ирээдүйн зөн совин, танин мэдэхүйн/ | 6 | 6000 | 3 | 3000 | 2 | 2000 |
| 107990 | Ерөнхий эрдмийн хичээлүүд англи-монгол хэл дээр №1 А.Дүрэм Б. Унших дасгал */Англи хэл сурах үндэсний шилдэг технологи/* | 2 | 10000 | 1 | 5000 | 1 | 5000 |
| 100021 | МОНГОЛЖИНГОО | 6 | 2700 | 3 | 1350 | 2 | 900 |
| 107660 | Математик 1-3 анги | - | - | 3 | 6000 | 2 | 4000 |
| 107661 | Математик 4-5 анги | - | - | 3 | 6000 | 2 | 4000 |
| 107662 | Математик 6-9 анги | - | - | 3 | 6000 | 2 | 4000 |
| 107663 | Математик 10-12 анги | - | - | 3 | 6000 | 2 | 4000 |
| 100873 | НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ | 6 | 3600 | 3 | 1800 | 2 | 1200 |
| 101001 | ОЮУНД ТУССАН ГЭГЭЭ | 6 | 6000 | 3 | 3000 | 2 | 2000 |
| 101227 | УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН СОНИН | 6 | 6000 | 3 | 3000 | 2 | 2000 |
| 100620 | ХАНЬ | 8 | 10400 | 4 | 5200 | 3 | 3900 |
| 101409 | ХӨДӨӨ АЖ АХУЙН МАРГААШ | 6 | 3000 | 3 | 1500 | 2 | 1000 |
| 101539 | СУРАГЧИЙН ЕРТӨНЦ | 3 | 4500 | 3 | 4500 | 2 | 3000 |
| 101016 | СЭТГЭЛ ЗҮЙЧ | 4 | 10800 | 2 | 5400 | 2 | 5400 |
| 101438 | СУРАГЧ | 5 | 15000 | 3 | 9000 | 2 | 6000 |
| 100651 | ЦОХ /хүүхдийн танин мэдэхүйн сонин бүх нүүр өнгөтөөр/ | 6 | 10000 | 3 | 5000 | 2 | 3400 |
| 100813 | ЭМЧ | 6 | 6000 | 3 | 3000 | 2 | 2000 |
| 101655 | Шамбалын гэрэл /2009 оны 12 дугаар/ | 1 | 15000 | 1 | 15000 | 1 | 15000 |
| 1102702 | “Математикийн цаг” I I анги */Захиалагчид “Өөрийн үнэлгээ 2-р анги” I ба II дэвтэр бэлэглэнэ/.* | Үндсэн 3 хавсралт 1 | | | 5900 | Захиалагч нарт “Математикийн цаг I-V анги” сонин ерөнхий очих ба зөвхөн хавсралт дугаараар ялгагдана. Хавсралт дугаарыг эхний дугаарын сонинтой хамт хүргүүлнэ. | |
| 1102703 | “Математикийн цаг” I I I анги /Захиалагчид “Өөрийн үнэлгээ 3-р анги” I ба II дэвтэр бэлэглэнэ/. | Үндсэн 3 хавсралт 1 | | | 5900 | | |
| 1102704 | “Математикийн цаг” I V анги /Захиалагчид “Өөрийн үнэлгээ 4-р анги” I ба II дэвтэр бэлэглэнэ/. | Үндсэн 3 хавсралт 1 | | | 5900 | | |
| 1102705 | “Математикийн цаг” V анги /Захиалагчид “Өөрийн үнэлгээ 5-р анги” I ба II дэвтэр бэлэглэнэ/. | Үндсэн 3 хавсралт 1 | | | 5900 | | |
| 1102706 | “Математикийн цаг” V I анги /Захиалагчид “Өөрийн үнэлгээ 6-р анги” I ба II дэвтэр бэлэглэнэ/. | Үндсэн 3 хавсралт 1 | | | 5900 | Захиалагч нарт “Математикийн цаг V I-IX анги” сонин ерөнхий очих ба зөвхөн хавсралт дугаараар ялгагдана. Хавсралт дугаарыг эхний дугаарын сонинтой хамт хүргүүлнэ. | |
| 1102707 | “Математикийн цаг” V I I анги /Захиалагчид “Өөрийн үнэлгээ 7-р анги” I ба II дэвтэр бэлэглэнэ/. | Үндсэн 3 хавсралт 1 | | | 5900 | | |
| 1102708 | “Математикийн цаг” V I I I анги /Захиалагчид “Өөрийн үнэлгээ 8-р анги” I ба II дэвтэр бэлэглэнэ/. | Үндсэн 3 хавсралт 1 | | | 5900 | | |
| 1102709 | “Математикийн цаг” IX анги /Захиалагчид “Өөрийн үнэлгээ 9-р анги” I ба II дэвтэр бэлэглэнэ/. | Үндсэн 3 хавсралт 1 | | | 5900 | | |
| 1102710 | “Математикийн цаг” X анги /Захиалагчид “Өөрийн үнэлгээ 10-р анги” I ба II дэвтэр бэлэглэнэ/. | Үндсэн 3 хавсралт 1 | | | 5900 | Захиалагч нарт “Математикийн цаг X-XII анги” сонин ерөнхий очих ба зөвхөн хавсралт дугаараар ялгагдана. Хавсралт дугаарыг эхний дугаарын сонинтой хамт хүргүүлнэ. | |
| 1102711 | “Математикийн цаг” X I анги /Захиалагчид “Өөрийн үнэлгээ 11-р анги” I ба II дэвтэр бэлэглэнэ/. | Үндсэн 3 хавсралт 1 | | | 5900 | | |
| 1102712 | “Математикийн цаг” XII анги /Захиалагчид “Өөрийн үнэлгээ 12-р анги” I ба II дэвтэр бэлэглэнэ/. | Үндсэн 3 хавсралт 1 | | | 5900 | | |
| 1102714 | Математикийн ажлын дэвтэр 2-р анги | | | 1 | 3600 | 2016-2017 оны хичээлийн жилд зориулан шинэчлэн хэвлэсэн. Тухайн ангийн математикийн хичээлээр судалж буй бүлэг сэдэв бүрээр суралцагч бие дааж болон эцэг эхийн хамтаар мэдлэг чадвараа бататгах зорилгоор асуултанд хариулах, нөхөх, гүйцээх, хэлбэрээр ажиллах дэвтэр юм. | |
| 1102715 | Математикийн ажлын дэвтэр 3-р анги | | | 1 | 3600 | | |
| 1102716 | Математикийн ажлын дэвтэр 4-р анги | | | 1 | 3600 | | |
| 1102717 | Математикийн ажлын дэвтэр 5-р анги | | | 1 | 3600 | | |
| 1102718 | Математикийн ажлын дэвтэр 6-р анги | | | 1 | 3600 | | |
| 1102719 | Математикийн ажлын дэвтэр 7-р анги | | | 1 | 3600 | | |
| 1102720 | Математикийн ажлын дэвтэр 8-р анги | | | 1 | 3600 | | |
| 1102721 | Математикийн ажлын дэвтэр 9-р анги | | | 1 | 3600 | | |
| 1102722 | Математикийн ажлын дэвтэр 10-р анги | | | 1 | 3600 | | |
| 1102723 | Математикийн ажлын дэвтэр 11-р анги | | | 1 | 3600 | | |
| 1102724 | Математикийн ажлын дэвтэр 12-р анги | | | 1 | 3600 | | |

### 4. ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Хагас жил | | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 101003 | АЛТАН НУТГИЙН МЭДЭЭ /Өмнөговь/ | 6 | 9000 | 3 | 4500 | 2 | 3000 |
| 101238 | ЦЭЦЭРЛЭГ МАНДАЛ /Архангай/ | 18 | 9000 | 6 | 3000 | 4 | 2000 |
| 101239 | АРХАНГАЙН АМЬДРАЛ /Архангай/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 125312 | АРХАНГАЙН ТОЛЬ | 24 | 11000 | 12 | 5500 | 8 | 4000 |
| 124774 | БАГАНУУРЫН АМЬДРАЛ /Багануур/ | 18 | 12000 | 9 | 6000 | 6 | 4000 |
| 101174 | БАЯНХОНГОР ТАЙМС /Баянхонгор/ | 18 | 12000 | 9 | 6000 | 6 | 4000 |
| 101212 | ӨЛКЕ ӨМИРИ / Баян-Өлгий/ | 18 | 12000 | 9 | 6000 | 6 | 4000 |
| 100999 | БУЛГАНЫ МЭДЭЭ / Булган/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101111 | ГОВИЙН ӨНГӨ ТӨРХ | 24 | 10000 | 12 | 5000 | 8 | 4000 |
| 163338 | ДОРНОГОВИЙН ШУУДАН | 12 | 6000 | 6 | 3000 | 4 | 2000 |
| 101157 | ДОРНОД /Дорнод/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 154053 | ДӨЛ /Дорнод/ | 12 | 6000 | 6 | 3000 | 4 | 2000 |
| 101180 | ДАЛАЙ ЭЭЖ | 18 | 14400 | 9 | 7200 | 6 | 4800 |
| 154461 | ДУНДГОВИЙН АМЬДРАЛ /Дундговь/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 100610 | ЗАВХАН /Завхан/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 105446 | АЛТАЙН МЭДЭЭ / Говь-Алтай/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 100802 | МОНГОЛ ГОВЬ / Өмнөговь/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 131363 | МОНГОЛ ЗАМАН | 12 | 9000 | 6 | 4500 | 4 | 3000 |
| 101672 | НАЛАЙХЫН АМЬДРАЛ /Налайх дүүрэг/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 201005 | НУТГИЙН СОЁМБО СЭТГҮҮЛ | 6 | 24000 | 3 | 12000 | 2 | 8000 |
| 190709 | НАР ТУССАН ЦАГ | 48 | 20000 | 24 | 10000 | 16 | 8000 |
| 100778 | ӨВӨРХАНГАЙН МЭДЭЭ /Өвөрхангай/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101004 | ӨВӨРХАНГАЙН ӨНГӨ /Өвөрхангай/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101666 | ӨНӨӨГИЙН БАЯНХОНГОР | 18 | 9000 | 9 | 4500 | 6 | 3000 |
| 105813 | ӨНӨӨГИЙН ДОРНОГОВЬ / Дорноговь/ | 18 | 12000 | 9 | 6000 | 6 | 4000 |
| 104085 | ӨНӨӨГИЙН ЭРДЭНЭТ | 24 | 8000 | 12 | 4000 | 8 | 2700 |
| 106003 | ӨНӨӨДРИЙН ЯЛАЛТ | 12 | 8400 | 6 | 4200 | 4 | 2800 |
| 101139 | СЭЛЭНГИЙН МЭДЭЭ /Сэлэнгэ/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 201009 | СОНИРХОЛТОЙ ДЭЛХИЙ /сэтгүүл/ | 6 | 24000 | 3 | 12000 | 2 | 4000 |
| 101642 | ТАНЫ ЭЛЧ / Өвөрхангай/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101624 | УВСЫН ӨНГӨ /Увс/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101095 | ХОВДЫН МЭДЭЭ / Ховд/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101607 | ХОВДЫН ТОЛЬ+Бизнес толь+Ирээдүйн толь | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 193342 | Хотын шуудан / Эрдэнэт/ | 18 | 14000 | 9 | 7000 | 6 | 4600 |
| 101097 | ХЭНТИЙН МЭДЭЭ / Хэнтий/ | 24 | 12000 | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101285 | ШИНЭ ЗУУНЫ ХЭНТИЙ | 12 | 7200 | 6 | 3600 | 4 | 2400 |
| 107391 | ШИНЭ МЭДЭЭ / Дархан/ | 18 | 12000 | 9 | 6000 | 6 | 4000 |
